

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Зам, тээврийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: САГ-2026/7/НА-СТА-ТЕЗ

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2026 он	Тусгай чиг үүргийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор: Д.Баярсайхан Утас: 51-261663 Цахим хаяг: bayarsaikhand@audit.gov.mn Аудитын менежер: Д.Энхдалай Утас: 51-260512 Цахим хаяг: enkhdalaid@audit.gov.mn Ахлах аудитор: Ц.Энхжаргал Утас: 51-261740 Цахим хаяг: enkhjargalts@audit.gov.mn
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	6
2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан	6
2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан	7
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	9
2.5 Төсвийн гүйцэтгэлийн тайлан	10
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	12
3. САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	13
3.1 Зам, тээврийн сайд, түүний эрхлэх асуудал	13
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	14
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	14
3.4.1 Мөнгөн хөрөнгө	15
3.4.2 Авлага	17
3.4.3 Урьдчилгаа.....	18
3.4.4 Бараа материал.....	18
3.4.5 Бусад эргэлтийн хөрөнгө.....	19
3.4.6 Урт хугацаат хөрөнгө оруулалт.....	19
3.4.7 Үндсэн хөрөнгө	20
3.4.8 Өр төлбөр	21
3.4.9 Засгийн газрын хувь оролцоо	22
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	22
3.5.1 Төсвийн төлөвлөлт	23
3.5.2 Төсвийн гүйцэтгэл	23
3.5.3 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл	25
3.5.4 Хөтөлбөр арга хэмжээний хүрэх үр дүн, хэрэгжилт	27
3.5.5 Нэмэлт төсөв	27
4. АУДИТЫН ТАЙЛАН	29
4.1 Ерөнхий зүйл	29
4.2 Материаллаг байдал	29
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт.....	29
4.4 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	30
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	30
4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд.....	30
4.5 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн.....	32
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	33
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	34
5.1 Харьяа байгууллагууд	34
5.2 Төсвийн ерөнхийлөн захирагч	34
5.2.1 Албан шаардлага	34
5.2.2 Зөвлөмж	35
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	38
7. ТӨЛБӨРИЙН АКТ, АЛБАН ШААРДЛАГУУД.....	42

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АЗЗАН	Авто замын засвар арчлалтын нэгтгэл
АЗННС	Авто замын норм, нормативын сан
АТҮТ	Авто тээврийн үндэсний төв
АХОЗШША	Агаарын хөлгийн осол, зөрчлийг шинжлэн шалгах алба
ЗГНХ	Засгийн газрын нөөц хөрөнгө
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө
ЗТЯ	Зам, тээврийн яам
ЗТХТ	Зам тээврийн хөгжлийн төв
ИНЕГ	Иргэний нисэхийн ерөнхий газар
ИНҮТ	Иргэний нисэхийн үндэсний төв
МИАТ	Монголын иргэний агаарын тээвэр
МУДЗ	Монгол Улсын далайн захиргаа
ТАЦ	Төлбөр авах цэг
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ТӨХХК	Төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани
УАЗС	Улсын авто замын сан
ҮОМШӨ	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчин
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХХНБОБ	Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал



ЗАМ, ТЭЭВРИЙН САЙД
Б.ДЭЛГЭРСАЙХАН ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР**

Засгийн газрын IV байр, Бага тойруу-3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26-04-37, Факс: (976-51) 26 42 30
Цахим шуудан: info@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2026.04.24 № 1138
танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Зам, тээврийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Хязгаарлалттай дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн санхүүгийн нэгтгэсэн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Зам, тээврийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь аудитын дүгнэлт өгөх үндэслэл болно.

Зам, тээврийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар илэрсэн нийт 358,893.2 сая төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаараа буюу нийт дүнгээрээ санхүүгийн нэгтгэсэн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй байна. Тухайлбал:

- Тайлант онд МИАТ ТӨХК 98,167.9 сая төгрөгөөр, Авто замын засвар арчлалтын нэгтгэл ТӨХК 21,736.3 сая төгрөгөөр, Иргэний нисэхийн ерөнхий газар 3,228.0 сая төгрөгөөр, Зам тээврийн хөгжлийн төв ТӨҮГ 5,476.3 сая төгрөгөөр, Авто тээврийн үндэсний төв ТӨҮГ 1,671.0 сая төгрөгөөр тус тус орлогын төлөвлөгөөнд хүрч, ажиллаагүй, орлогыг дутуу бүрдүүлсэн;
- Монголын төмөр зам ТӨХК 4,237.9 сая төгрөгийн авлага, 26,302.6 сая төгрөгийн өглөг, МИАТ ТӨХК 14,656.8 сая төгрөгийн авлага, 1,785.8 сая төгрөгийн өглөг, Иргэний нисэхийн үндэсний төв ТӨХК 1,363.5 сая төгрөгийн авлага, 3,482.0 сая төгрөгийн өглөг, Иргэний нисэхийн ерөнхий газар 433.1 сая төгрөгийн авлага, 933.4 сая төгрөгийн өглөгийг тус тус тооцоо нийлж, актаар баталгаажуулаагүй;

Z:\Yawsan_Bichig\2026\0424 SAG-36 Docx

1526090658

- Цалингийн зардлыг хэтрүүлсэн, ажлын байрны жагсаалт, орон тоогоор батлаагүй албан тушаалын орон тоог бий болгож, хавсран ажилласан цалингийн нэмэгдэл олгосон, цалингийн нэмэгдэл, үр дүнгийн урамшуулал, илүү цагийн хөлсийг холбогдох хууль тогтоомжийн дагуу олгоогүй, буруу тооцоолж, илүү олгосон. Үүнд: батлагдсан цалингийн төсвийг МИАТ ТӨХК 2,893.0 сая төгрөгөөр, Иргэний нисэхийн үндэсний төв ТӨХК 963.2 сая төгрөгөөр тус тус хэтрүүлсэн, Иргэний нисэхийн ерөнхий газар улирлын мөнгөн урамшууллын дээд хэмжээг хэтрүүлэн сар бүр 40 хувиар тооцож урамшуулалд нийт 1,340.5 сая төгрөгийг олгосон байна.

Дээрх зөрчил нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20, 21 дүгээр зүйл, Төсвийн тухай хуулийн 5, 6, 14, 16, 22 дугаар зүйл, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18, 20 дугаар зүйлийн холбогдох заалтуудтай нийцээгүй, санхүүгийн нэгтгэсэн тайлангийн иж бүрэн байх, тохиолдсон байх, ангилал, оршин байх, үнэлгээ ба хуваарилалт, толилуулга батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх нийт 918,076.3 сая төгрөгийн 96 төсөл, арга хэмжээ батлагдсан байна. Үүнээс 652,842.2 сая төгрөгийн 81 төсөл, арга хэмжээ өмнөх оноос шилжин хэрэгжихээр, 265,234.1 сая төгрөгийн 14 төсөл, арга хэмжээг шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Иргэний нисэхийн ерөнхий газар нь Иргэний нисэхийн үндэсний төвийн санхүүгийн тайланг нэгтгэж, санхүүгийн нэгтгэсэн тайлан бэлтгэдэг байсан бөгөөд Засгийн газрын 2024 оны 189 дүгээр тогтоолоор Иргэний нисэхийн ерөнхий газар Засгийн газрын тохируулагч агентлаг, Засгийн газрын 193 дугаар тогтоолоор Иргэний нисэхийн үндэсний төв 100.0 хувь төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани болон өөрчлөн зохион байгуулагдаж, тусдаа санхүүгийн тайлан бэлтгэн, тайлагнаж байна.

Бусад асуудлын хэсэг

Төр, хувийн хэвшлийн түншлэлээр зураг төсөл боловсруулах–барих–ашиглах–шилжүүлэх нөхцөлтэй Тавантолгой – Гашуунсухайт чиглэлийн 250 км хүнд даацын хатуу хучилттай авто зам, Тавантолгой–Манлай–Ханги чиглэлийн тусгай зориулалтын авто зам, Өмнөговь аймгийн Ханхонгор сумын Тавантолгой–Барууннаран чиглэлийн 32 км авто замын төгсгөлөөс "Цагаандэл уул" хилийн боомт хүртэлх 270 км тусгай зориулалтын авто зам болон барих шилжүүлэх нөхцөлтэй Дашинчилэн–Орхоны гүүр чиглэлийн замаас Өлзийт сум, Өлзийт сумаас Мөрөн–Тариалан чиглэлийн замын төгсгөлийг холбох 120 км хатуу хучилттай авто замын төсөл хэрэгжиж байна.

Хувийн хөрөнгө оруулалтаар Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан сумын нутагт орших “Эрээн толгой” нүүрсний уурхайгаас Бичигтийн боомт хүртэлх 110.3 км тусгай зориулалтын авто зам, Баянхонгор аймгийн Шинэжинст сумын нутагт орших Хотгорын уурхайгаас Нарийнсухайт–Шивээхүрэн чиглэлийн авто замд холбох 295 км тусгай

зориулалтын авто зам, Дорнод аймгийн Баянтүмэн сумын нутагт орших “Хашаатын цав” нүүрсний уурхайгаас Хавиргын боомт хүртэлх 96.4 км тусгай зориулалтын авто замын төслийг тус тус хэрэгжүүлж байна.

Санхүүгийн нэгтгэсэн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн нэгтгэсэн тайланд төсвийн ерөнхийлөн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн ерөнхийлөн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн нэгтгэсэн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн нэгтгэсэн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд Аудитын дээд байгууллагын олон улсын стандартын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн нэгтгэсэн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.



С.МАГНАЙСҮРЭН

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,917,749,912.9	2,428,405,333.0
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	359,865,085.3	231,708,390.5
33	АВЛАГА	249,544,543.9	388,066,746.3
34	УРЬДЧИЛГАА	71,738,546.3	75,705,733.3
35	БАРАА МАТЕРИАЛ	102,189,602.1	127,697,480.3
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	1,134,412,135.3	1,605,226,982.6
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	7,438,232,935.8	6,650,323,069.5
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	742,417,070.7	48,652,870.0
37200	Үнэт цаас	693,765,710.7	1,510.0
37300	Урт хугацаат зээл	48,651,360.0	48,651,360.0
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	6,695,815,865.1	6,601,670,199.5
39200	Биет хөрөнгө	5,581,658,579.5	5,551,184,875.2
39300	Биет бус хөрөнгө	1,080,633,135.3	532,324,889.1
39400	Бусад хөрөнгө /ТӨҮГ/	33,524,150.3	518,160,435.2
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	9,355,982,848.7	9,078,728,402.5
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	2,843,424,439.2	2,537,308,971.9
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	510,081,175.7	918,237,771.4
41200	Богино хугацаат зээлийн өглөг	38,029,988.0	26,824,908.5
41300	Өглөг	275,849,972.0	746,686,847.6
41400	Урьдчилж орсон орлого	196,201,215.7	144,726,015.3
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	2,333,343,263.5	1,619,071,200.6
42100	Урт хугацаат үнэт цаас	1,475,504,630.9	870,268,060.9
42200	Урт хугацаат зээл	857,838,632.6	748,803,139.7
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	6,512,558,409.4	6,541,419,430.6
51	Засгийн газрын хувь оролцоо	6,512,445,058.9	6,541,306,080.0
51100	Засгийн газрын оруулсан капитал	2,172,015,649.5	1,723,481,703.0
51101	Өмч /төрийн/ /ТӨҮГ/	94,446,382.9	545,075,370.7
51102	Өмч /хувийн/ /ТӨҮГ/	490.0	490.0
51105	Нэмж төлөгдсөн капитал /ТӨҮГ/	32,583.8	32,583.2
51106	Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/	945,126,023.4	958,075,515.1
51200	Хуримтлагдсан үр дүн	1,042,633,293.0	1,061,725,926.4
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,257,974,343.2	2,252,641,892.5
51500	Бодлогын өөрчлөлт алдааны залруулга	216,293.0	272,599.1
52	Хяналтын бус хувь оролцоо	113,350.6	113,350.6
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	9,355,982,848.7	9,078,728,402.5

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,562,431,417.0	1,394,244,206.2
11	ТАТВАРЫН ОРЛОГО	0.0	18,555,052.2
112	Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого	0.0	18,555,052.2
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	869,022,234.7	1,375,689,154.0
120	Нийтлэг татварын бус орлого	869,022,234.7	641,050,333.4
122	Тусламжийн орлого	0.0	734,638,820.6
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	693,409,182.3	0.0
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	951,054,722.0	1,659,081,609.6
21	УРСГАЛ ЗАРДАЛ	951,054,722.0	1,081,950,416.7
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	857,634,745.3	994,746,821.7
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	106,261,097.6	23,903,558.2
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	13,488,840.8	50,069,265.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	4,087,709.6	1,094,337.6
2104	Хангамж, бараа материалын зардал	8,684,097.3	1,186,482.8
2105	Нормативт зардал	126,752.4	258,414.6
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,899,624.2	421,054.2
2107	Томилолт, зочны зардал	3,680,328.4	1,743,961.5
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	175,055,731.7	398,099,748.3
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	541,350,563.5	517,969,999.3
212	ТАТААС	3,284,421.3	3,519,230.4
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	90,135,555.4	83,684,364.6
22	Хөрөнгийн зардал	0.0	577,131,192.9
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	611,376,695.0	-264,837,403.4
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	156,144.2	11,678,971.4
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	217,466,514.6	197,441,693.8
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	394,066,324.6	-450,600,125.9

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	2,306,846,398.2	3,156,857,451.3
11	ТАТВАРЫН ОРЛОГО	129.0	452.8
112	Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого	129.0	452.8
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,607,788,269.7	3,156,856,998.5
120	Нийтлэг татварын бус орлого	1,607,788,269.7	2,417,008,368.8
	Тусламжийн орлого	0.0	739,848,629.7
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	699,057,999.6	-
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,461,890,371.7	2,302,776,430.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,461,890,371.7	2,302,776,430.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,353,736,500.7	2,209,222,085.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	240,452,781.3	323,940,884.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	46,880,606.5	50,907,342.9
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	20,179,792.3	24,193,804.6
2104	Хангамж, бараа материалын зардал	469,634,984.6	557,946,745.2
2105	Нормативт зардал	37,294.4	-
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	2,497,426.3	345,506.3
2107	Томилолт, зочны зардал	3,661,276.3	1,807,089.3
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	565,133,601.6	1,183,610,596.8
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,258,737.4	66,470,116.8
211	ХҮҮ	83,071.7	-
212	ТАТААС	5,777,693.7	2,503,870.5
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	102,293,105.6	91,050,474.1
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	844,956,026.5	854,081,020.8
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)	35,874,612.0	7,832,466.6
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	755,715,084.5	1,129,409,409.4
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	755,715,084.5	1,129,409,409.4
2200	Дотоод эх үүсвэрээр	755,715,084.5	1,129,409,409.4
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-719,840,472.5	-1,121,576,942.8
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	37,141,521.6	139,339,227.2
14	Бусад эх үүсвэр	85,751,841.2	223,039,640.5
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	48,610,319.6	83,700,413.3
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	162,257,075.6	-128,156,694.8
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	197,608,009.7	359,865,085.3
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	359,865,085.3	231,708,390.5

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6,317,628,244.1		6,317,628,244.1
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-215,603,168.3		-215,603,168.3
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	6,102,025,075.8		6,102,025,075.8
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	366,122.7		366,122.7
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	193,527.1		193,527.1
7	Өмчид гарсан өөрчлөлт	19,444,762.4		19,444,762.4
8	Зарласан ногдол ашиг	-3,537,403.2		-3,537,403.2
9	Тайлант үеийн үр дүн	394,066,324.6		394,066,324.6
10	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6,512,558,409.4		6,512,558,409.4
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	495,667,103.4		495,667,103.4
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	7,008,225,512.8		7,008,225,512.8
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	3,374,368.2		3,374,368.2
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	-3,628.7		-3,628.7
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөгдөөгүй олз, гарз	-543,668,606.8		-543,668,606.8
17	Өмчид гарсан өөрчлөлт	535,261,974.2		535,261,974.2
18	Зарласан ногдол ашиг	-11,170,063.2		-11,170,063.2
19	Тайлант үеийн үр дүн	-450,600,125.9		-450,600,125.9
20	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	6,541,419,430.6		6,541,419,430.6

Зам, тээврийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн
нэгтгэсэн тайланд хийсэн аудитын тайлан

2.5 Төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/Төгрөгөөр/

Данс код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	1,013,502,029,400.00	765,739,349,137.76	247,762,680,262.24	75.6
12	Татварын бус орлого	1,013,502,029,400.00	765,739,349,137.76	247,762,680,262.24	75.6
120	Нийтлэг татварын бус орлого	30,356,000,000.00	34,229,889,223.24	-3,873,889,223.24	112.8
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого /үндсэн/	30,356,000,000.00	34,229,889,223.24	-3,873,889,223.24	112.8
122	Тусламжийн орлого	983,146,029,400.00	731,509,459,914.52	251,636,569,485.48	74.4
122005	Төсвөөс санхүүжих	983,146,029,400.00	731,509,459,914.52	251,636,569,485.48	74.4
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,013,502,029,400.00	761,865,459,914.52	251,636,569,485.48	75.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	22,630,821,300.00	21,019,780,354.52	1,611,040,945.48	92.9
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	18,282,843,600.00	17,959,595,462.14	323,248,137.86	98.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	9,904,465,600.00	9,794,549,665.11	109,915,934.89	98.9
210101	Үндсэн цалин	5,996,883,300.00	5,977,426,269.06	19,457,030.94	99.7
210102	Нэмэгдэл	2,915,360,600.00	1,838,014,740.80	1,077,345,859.20	63.0
210103	Унаа хоолны хөнгөлөлт	745,113,500.00	1,374,375,699.94	-629,262,199.94	184.5
210104	Урамшуулал	247,108,200.00	604,732,955.31	-357,624,755.31	244.7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,311,357,100.00	1,219,675,779.11	91,681,320.89	93.0
210201	Тэтгэврийн даатгал	910,080,700.00	831,675,948.14	78,404,751.86	91.4
210202	Тэтгэмжийн даатгал	100,351,800.00	97,495,266.88	2,856,533.12	97.2
210203	ҮОМШӨ-ий даатгал	50,204,400.00	53,680,285.28	-3,475,885.28	106.9
210204	Ажилгүйдлийн даатгал	50,133,300.00	47,138,310.68	2,994,989.32	94.0
210205	Эрүүл мэндийн даатгал	200,586,900.00	189,685,968.13	10,900,931.87	94.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	146,472,900.00	133,935,911.12	12,536,988.88	91.4
210301	Гэрэл, цахилгаан	28,628,600.00	26,443,923.34	2,184,676.66	92.4
210302	Түлш, халаалт	38,837,700.00	38,268,841.99	568,858.01	98.5
210303	Цэвэр, бохир ус	20,640,300.00	10,856,845.79	9,783,454.21	52.6
210304	Байрны түрээс	58,366,300.00	58,366,300.00	0.00	100.0
2104	Хангамж, бараа материалын зардал	177,322,900.00	157,800,887.87	19,522,012.13	89.0
210401	Бичиг хэрэг	36,345,000.00	40,799,090.00	-4,454,090.00	112.3
210402	Тээвэр, шатахуун	11,100,000.00	9,900,000.00	1,200,000.00	89.2
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	58,360,500.00	51,597,763.87	6,762,736.13	88.4
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	71,517,400.00	55,504,034.00	16,013,366.00	77.6
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	260,009,400.00	214,915,495.00	45,093,905.00	82.7
210601	Багаж, техник, хэрэгсэл	12,075,900.00	20,533,170.00	-8,457,270.00	170.0
210602	Тавилга	6,186,100.00	6,186,100.00	0.00	100.0
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	7,173,600.00	597,125.00	6,576,475.00	8.3
210604	Урсгал засвар	234,573,800.00	187,599,100.00	46,974,700.00	80.0
2107	Томилолт, зочны зардал	251,913,500.00	251,280,000.00	633,500.00	99.7
210701	Гадаад албан томилолт	140,360,700.00	147,619,889.18	-7,259,189.18	105.2
210702	Дотоод албан томилолт	111,552,800.00	103,660,110.82	7,892,689.18	92.9
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,129,475,700.00	6,087,111,223.93	42,364,476.07	99.3
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,925,986,800.00	5,925,984,860.00	1,940.00	100.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	14,792,400.00	2,250,000.00	12,542,400.00	15.2
210803	Даатгалын үйлчилгээ	7,174,000.00	1,455,148.00	5,718,852.00	20.3
210804	Тээврийн хэрэгслийн татвар	3,585,600.00	1,110,648.00	2,474,952.00	31.0
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	1,388,900.00	67,000.00	1,321,900.00	4.8
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	142,692,800.00	130,097,217.93	12,595,582.07	91.2

Зам, тээврийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын тайлан

210807	Газрын төлбөр	13,921,200.00	10,917,350.00	3,003,850.00	78.4
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	2,873,400.00	2,509,600.00	363,800.00	87.3
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	17,060,600.00	12,719,400.00	4,341,200.00	74.6
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	101,826,500.00	100,326,500.00	1,500,000.00	98.5
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	14,600,000.00	14,600,000.00	0.00	100.0
212	ТАТААС	87,226,500.00	85,726,500.00	1,500,000.00	98.3
2122	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	2,892,990,700.00	2,422,832,900.00	470,157,800.00	83.7
212201	Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	2,892,990,700.00	2,422,832,900.00	470,157,800.00	83.7
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,892,990,700.00	2,422,832,900.00	470,157,800.00	83.7
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	1,454,987,000.00	637,351,992.38	817,635,007.62	43.8
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	210,751,900.00	0.00	210,751,900.00	0.0
2132	Бусад урсгал шилжүүлэг	210,751,900.00	0.00	210,751,900.00	0.0
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,244,235,100.00	637,351,992.38	606,883,107.62	51.2
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	53,116,800.00	18,650,000.00	34,466,800.00	35.1
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	288,604,900.00	286,400,000.00	2,204,900.00	99.2
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	902,513,400.00	332,301,992.38	570,211,407.62	36.8
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	990,871,208,100.00	740,845,679,560.00	250,025,528,540.00	74.8
220001	Барилга байгууламж	870,156,632,700.00	620,977,540,613.25	249,179,092,086.75	71.4
221001	Их засвар	47,919,600,000.00	47,073,163,546.75	846,436,453.25	98.2
223001	Бусад хөрөнгө	72,794,975,400.00	72,794,975,400.00	0.00	100.0
III	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	0.00	3,873,889,223.24	-3,873,889,223.24	
31	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	0.00	-3,873,889,223.24	3,873,889,223.24	
310001	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	0.00	3,873,889,223.24	-3,873,889,223.24	
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	59,655,777.51	-59,655,777.51	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	181,266,924.35	-181,266,924.35	
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	527	413	114	78.4
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	3	3	0	100.0
610001	Төсвийн байгууллага	3	3	0	100.0
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	256	252	4	98.4
620001	Удирдах ажилтан	12	18	-6	150.0
620002	Гүйцэтгэх ажилтан	244	234	10	95.9

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Тайлант хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан

/Төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН		8,012,278,901.00
ТАТВАРЫН БУС ОРЛОГО		8,012,278,901.00
Тусламжийн орлого		8,012,278,901.00
Хандив тусламж /дотоод/		8,012,278,901.00
Нэмэлт санхүүжилтийн орлогос		8,012,278,901.00
ЗГНХ,ЗДНХ,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		2,660,845,076.00
Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		90,640,207.00
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		5,260,793,618.00
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		2,660,845,076.00
УРСГАЛ ЗАРДАЛ		2,660,845,076.00
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		2,660,845,076.00
Бараа үйлчилгээний бусад зардал		2,660,845,076.00
Бараа үйлчилгээний бусад зардал		2,660,845,076.00
ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ		5,351,433,825.00
Алдагдлыг санхүүжүүлэх эх үүсвэр		(5,351,433,825.00)
Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт		(5,351,433,825.00)

3. САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Зам, тээврийн сайд, түүний эрхлэх асуудал

Зам, тээврийн яам нь үйл ажиллагааны эрхэм зорилгоо “Эдийн засгийн өсөлтийг тэтгэх зам, тээвэр, эрэлт, нийлүүлэлтийн тэнцвэрийг хангах логистикийн оновчтой сүлжээг өргөжүүлэн хөгжүүлж, хэрэглэгчийн хэрэгцээ, шаардлагад бүрэн нийцсэн аюулгүй, ая тухтай, өртөг багатай, өрсөлдөхүйц, чанартай, өндөр бүтээмжтэй, технологид суурилсан, цахим өгөгдөлд тулгуурласан үр ашигтай тээврийн үйлчилгээг бий болгох.” гэж тодорхойлсон байна. Зам, тээврийн сайд эрхлэх асуудлын хүрээндээ тээврийн тогтолцоог хөгжүүлэх бодлого, зохицуулалт, төмөр замын тээвэр, иргэний нисэх, авто тээвэр, авто зам, далай ашиглах болон усан замын тээврийн асуудлыг хамааран ажиллаж байна.

Тайлант онд Хилийн боомтуудыг төмөр зам болон хатуу хучилттай авто замаар үе шаттайгаар бүрэн холбон, тээвэр, логистикийн өрсөлдөх чадварыг дээшлүүлэн ачаа тээврийн урсгалыг сайжруулж, цаашид транзит улс болох суурь нөхцөлийг бүрдүүлэх зорилгын хүрээнд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Үүнд:

- Төмөр замын бүтээн байгуулалтыг эрчимжүүлэн, төмөр замын тээвэрлэлтийн хөдөлгөөний зохицуулалт, уялдаа холбоог сайжруулан, 50.0 сая тонн ачаа, 2.5 сая зорчигч тээвэрлэх бодлого, хэрэгжилтийг зохион байгуулах;
- Олон улсын болон бүс нутгийн авто тээвэрлэлтэд оролцох боломжийг нэмэгдүүлэх, техникийн үзлэгийн чадавхыг бэхжүүлэх, авто тээврийн үйлчилгээг иргэдэд шуурхай хүргэх бодлого зохицуулалтыг хэрэгжүүлэн ачаа тээвэрлэлтийн хэмжээг 90.0 сая тонн, зорчигч тээвэрлэлтийг 146.0 саяд хүргэх;
- Хилийн боомтуудыг хатуу хучилттай авто замаар холбох, бүсчилсэн хөгжлийг дэмжих авто замын төслүүдийг хэрэгжүүлэх, Монгол Улсын үндэсний авто замын сүлжээнд эзлэх хатуу хучилттай авто замыг нэмэгдүүлэх, авто замын ашиглалтын байнгын бэлэн байдлыг нэмэгдүүлэх цогц арга хэмжээ авч хэрэгжүүлэх;
- Агаарын тээврийн үйлчилгээг өргөжүүлэн, олон улсын өнгөрөлтийн нислэг, буулт хөөрөлтийг нэмэгдүүлэх;
- Далай ашиглалтын үйл ажиллагааг өргөжүүлэх, хяналтыг сайжруулж, зөрчлийн тоог бууруулах;
- Орон нутгийн тээвэр логистикийн нэгдсэн сүлжээг үе шаттайгаар байгуулж, олон улсын болон бүсийн тээвэр логистикийн сүлжээнд холбох нөхцөлийг бүрдүүлэх;
- Зам, тээврийн салбараас үүдэлтэй уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах бодлого зорилтыг хэрэгжүүлэх;
- Салбарын хөгжлийг дэмжсэн эрх зүйн орчныг бүрдүүлэх;
- Зам, тээврийн салбарын үйл ажиллагааг өргөжүүлэх, нэгдсэн бодлогын төсөл, төлөвлөлтийг батлуулах;
- Төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллыг хэрэгжүүлж, эрх зүйн зохицуулалтыг хангаж, салбарын гадаад хамтын ажиллагааг өргөжүүлж, санхүү, хөрөнгө оруулалтын төлөвлөлтийг зохицуулж, хэрэгжүүлэх;
- Зам, тээврийн салбарын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэхэд чиглэсэн үнэлгээ хийх;
- Зам, тээврийн салбарын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, зөрчил, дутагдлыг бууруулах арга хэмжээ авах.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Зам, тээврийн сайд нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Засгийн газрын тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Авто замын тухай хууль, Авто тээврийн тухай хууль, Далай ашиглах тухай хууль, Иргэний нисэхийн тухай хууль, Нийтийн

албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай, Улсын нисэхийн тухай хууль, Усан замын тээврийн тухай хууль, Төмөр замын тээврийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль болон бусад холбогдох хууль, тогтоомжид нийцүүлэн чиг үүргээ хэрэгжүүлж байна.

Тайлант хугацаанд төсвийн ерөнхийлөн захирагчийн үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомжууд болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Тухайлбал:

- Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай;
- Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай.

Удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэхэд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн нэгтгэсэн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн нэгтгэсэн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын зорилго оршино.

Зам, тээврийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Санхүүгийн үйл ажиллагаандаа Зам, тээврийн хөгжлийн сайдын 2020 оны А/54 дүгээр тушаалаар баталсан “Авто замын салбарын нягтлан бодох бүртгэлийн бодлогын жишиг баримт бичиг”-ийг мөрдөн ажиллаж байгаа бөгөөд холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Зам, тээврийн сайд 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангаа Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 3.0 хувь буюу 277,254.4 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/
			Өсөлт (+) Бууралт (-)
Мөнгөн хөрөнгө	359,865.1	231,708.4	-128,156.7
Авлага	249,544.5	388,066.7	138,522.2
Урьдчилгаа	71,738.5	75,705.7	3,967.2
Бараа материал	102,189.6	127,697.5	25,507.9
Бусад эргэлтийн хөрөнгө	1,134,412.1	1,605,227.0	470,814.9
САГ-2026/7/НА-СТА-ТЕЗ			14

Зам, тээврийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын тайлан

Урт хугацаат хөрөнгө оруулалт	742,417.1	48,652.9	-693,764.2
Үндсэн хөрөнгө	6,695,815.9	6,601,670.2	-94,145.7
Нийт хөрөнгийн дүн	9,355,982.8	9,078,728.4	-277,254.4
Нийт өр төлбөр	2,843,424.4	2,537,309.0	-306,115.4
Цэвэр хөрөнгө өмчийн дүн	6,512,558.4	6,541,419.4	28,861.0
Өр төлбөр ба эздийн өмчийн дүн	9,355,982.8	9,078,728.4	-277,254.4

Эх сурвалж: Зам, тээврийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Дансны үлдэгдэлд өмнөх оны үзүүлэлтээс мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, бусад эргэлтийн хөрөнгө, урт хугацаат хөрөнгө оруулалт, үндсэн хөрөнгө, өр төлбөр, цэвэр хөрөнгө өмчийн данснүүдэд материаллаг өөрчлөлт гарсан байна.

Иргэний нисэхийн ерөнхий газар нь Иргэний нисэхийн үндэсний төвийн санхүүгийн тайланг нэгтгэж, санхүүгийн нэгтгэсэн тайлан бэлтгэдэг байсан бөгөөд Засгийн газрын 2024 оны 189 дүгээр тогтоолоор Иргэний нисэхийн ерөнхий газар Засгийн газрын тохируулагч агентлаг, Засгийн газрын 193 дугаар тогтоолоор Иргэний нисэхийн үндэсний төв 100.0 хувь төрийн өмчит хязгаарлагдмал хариуцлагатай компани болон өөрчлөн зохион байгуулагдаж, тусдаа санхүүгийн тайлан бэлтгэн, тайлагнаж байна. Байгууллагууд эхлэлтийн болон дуусгалтын санхүүгийн тайлан бэлтгээгүй, Иргэний нисэхийн үндэсний төв өмнөх оны аудитаар 551,385.8 сая төгрөгийн нийт хөрөнгийн үлдэгдэлтэй баталгаажуулсныг эрх бүхий байгууллагын тушаал шийдвэргүйгээр эхний үлдэгдлийг тайлагнаагүй, буруу бэлтгэснийг аудитын явцад залруулсан.

Мөн МТЗ ТӨХК Монголиан порт групп ХХК-ийн 51.0 хувь, Шивээхүрэн төмөр зам ХХК-ийн 51.0 хувь, Шинэ төмөр зам ХХК-ийн 100.0 хувийг эзэмшдэг. Монголиан порт групп ХХК, Шинэ төмөр зам ХХК 2025 оны санхүүгийн тайлангаа Төрийн аудитын байгууллагад ирүүлээгүй, МТЗ ТӨХК нэгдсэн санхүүгийн тайлангаа аудитад хамруулаагүй байна.

3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгө дансны эцсийн үлдэгдэл 231,708.4 сая төгрөг болж, өмнөх оноос 128,156.7 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/
			Өсөлт (+) Бууралт (-)
Касст байгаа бэлэн мөнгө	190.6	68.1	-122.5
Банканд байгаа бэлэн мөнгө	358,352.4	231,640.3	-126,712.1
Замд яваа мөнгөн хөрөнгө	1,322.1	0.0	-1,322.1
Дүн	359,865.1	231,708.4	-128,156.7

Эх сурвалж: Зам, тээврийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Мөнгөн хөрөнгийн дансны 68.1 сая төгрөг касст, 231,640.3 сая төгрөг харилцах дансанд байна. Үүнээс 2,661.9 сая төгрөг арилжааны Чингис хаан банканд байршиж байна.

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл буурсан нь төрийн өмчит компаниудын болон ЗТЯ-ны барьцаа хөрөнгийн дансны үлдэгдэл буурсантай холбоотой байна. Үүнд:

- ЗТЯ-ны барьцаа хөрөнгийн дансанд 76 ажлын 30,489.8 сая төгрөгийн барьцааг байршуулж, 68 ажлын 111,843.8 сая төгрөгийн барьцааг чөлөөлсөн;
- МТЗ ТӨХК: Засгийн газрын 2025 оны 86 дугаар тогтоолоор Багахангай-Хөшигийн хөндий төслийг санхүүжүүлж, Сангийн яамтай байгуулсан “Төмөр замын хөдлөх, бүрэлдэхүүний паркийг нэмэгдүүлэх”, “Төмөр замын хөдлөх бүрэлдэхүүн нийлүүлэх”,

- “Бүс нутгийн логистикийн төвийг хөгжүүлэх” төслүүдийн дамжуулан зээлдүүлэх зээлийн эргэн төлөлт хийгдэж, мөнгөн хөрөнгө 54,847.8 сая төгрөгөөр буурсан;
- АТҮТ ТӨҮГ: Нийт орлогын төлөвлөгөө 1,671.0 сая төгрөгөөр тасарч, нийт зардлыг төлөвлөгөөнөөс 1,563.7 сая төгрөгөөр хэтрүүлсэн, улсын төсөвт 9,388.6 сая төгрөг, төрийн өмчийн ногдол ашгийн өглөг 5,650.6 сая төгрөгийг төвлөрүүлснээс мөнгөн хөрөнгө 21,920.3 сая төгрөгөөр буурсан;
 - ИНҮТ ТӨХХК: Хөрөнгө оруулалтын 21,372.8 сая төгрөгийн төсөл, арга хэмжээ хэрэгжээгүйгээс харилцах данс дахь мөнгөн хөрөнгө нэмэгдсэн нь голлон нөлөөлсөн байна.

Аудитын илрүүлэлт: Тайлант онд мөнгөн хөрөнгө зарцуулахтай холбоотой дараах зөрчлүүд илэрсэн. Үүнд:

- ИНЕГ: Албан хаагчдын үр дүнгийн урамшууллыг Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолоор баталсан журамд заасан улирлын мөнгөн урамшууллын дээд хэмжээг хэтрүүлэн сар бүр 40.0 хувиар тооцож урамшуулалд нийт 1,340.5 сая төгрөг, ИНЕГ-ын 2025 оны 372 дугаар тушаалаар ажилтнуудад 5.0 сая төгрөг хүртэлх нэмэгдэл хөлс тооцож нийт 463.2 сая төгрөгийг тус тус олгосон;
- ИНҮТ ТӨХХК: Цалингийн батлагдсан төсвийг 963.2 сая төгрөгөөр хэтрүүлсэн, зохион байгуулалтын бүтэц, ажлын байрны жагсаалт, орон тоонд батлагдаагүй кассын нярвын орон тоог бий болгон 12 ажилтанд ажил хавсран гүйцэтгэх тушаал гаргаж, 30.0 хувийн цалингийн нэмэгдэл нийт 29.2 сая төгрөгийг олгосон, хөдөлмөрийн дотоод журамд заасан холбогдох заалтыг зөрчиж, иргэний нисэхийн салбарт ажилласан жилээс хамааруулан олгохоор заасан тэтгэмжийг 7-8 сар ажилласан 5 ажилтанд нийт 210.0 сая төгрөгөөр илүү олгосон;
- МТЗ ТӨХК: Ээлжийн амралтын хуваарь батлаагүй, ажилчдын ээлжийн амралтыг биеэр эдлүүлэх нөхцөл боломжоор хангахгүйгээр нэр бүхий 785 ажилтныг ээлжийн амралттай байх хугацаанд ажиллуулж цалин хөлс олгосон, спортын арга хэмжээний зардалд 59.7 сая төгрөг, мэдээ мэдээлэл, нэвтрүүлэг хийлгэхэд 150.0 сая төгрөгийг тус тус зарцуулсан;
- МИАТ ТӨХК: Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 13/24 дүгээр тогтоолоор цалингийн санг 87,712.1 сая төгрөгөөр баталснаас гүйцэтгэлээр цалинг 2,893.0 сая төгрөгөөр хэтрүүлсэн, Өвлийн улиралд дуудлагын бэлэн байдлыг хангах зорилгоор 22 автомашинд 4-6 сарын хугацаатай дулаан зогсоолын гэрээ байгуулж 63.7 сая төгрөг төлснөөс 9 автомашин нэгжийн дуудлагад явдаггүй, газрын дарга нарт үйлчилдэг 9 автомашины дулаан зогсоолын төлбөрт 25.0 сая төгрөг зарцуулсан;
- АХОЗШША: Албаны дарга албан хаагчдын албан тушаалын ангилал зэрэглэл, цалингийн шатлал тодорхой бус байхад тушаал гаргаж, үндсэн цалинг 2 удаа 15.0-51.2 хувиар нэмэгдүүлж, олгосон. Албаны дарга өөртөө үндсэн цалинг 3 дугаар сард 58.2 хувиар буюу 1.8 сая төгрөгөөр, 7 дугаар сард 26.0 хувиар буюу 1.3 сая төгрөгөөр тус тус нэмж, удаан жилийн нэмэгдлийг үндсэн цалингаас 30.0 хувиар тооцож, нийт 28.5 сая төгрөгийг илүү авсан. Олон улсын иргэний нисэхийн байгууллагаас 2026 онд хийгдэх аудитын шалгалтад хамрагдах бэлтгэл ажлыг хангах ажлын хэсэг байгуулж, албан хаагчдад 39.4 сая төгрөгийн цалингийн нэмэгдэл олгосон;
- Ойн арга хэмжээ зохион байгуулахад ИНҮТ ТӨХХК 1,410.1 сая төгрөг, ИНЕГ 1,066.4 сая төгрөг, МИАТ ТӨХК 65.0 сая төгрөг, ХХНОБ ТӨХКК 14.4 сая төгрөгийг тус тус зарцуулсан;
- Томилолтоор ажилласан албан хаагчдын цалин хөлсийг тооцохдоо хоол унааны мөнгийг давхардуулан олгосон /МТЗ ТӨХК 63.7 сая төгрөг, ИНҮТ ТӨХХК 62.4 сая төгрөг, ИНЕГ 7.7 сая төгрөг, ИНҮТ Өндөрхаан нисэх буудал 1.2 сая төгрөг, АТҮТ Төв салбар 0.75 сая төгрөг, ИНҮТ Булган нисэх буудал 0.7 сая төгрөг, ТАЦ 0.3 сая төгрөг/;
- Томилолтын тушаал шийдвэргүй, анхан шатны баримтын бүрдэл дутуу, томилолтын тайлан бэлтгээгүй, шууд зардалд бүртгэсэн, томилолтын зардлыг илүү олгосон /ИНЕГ 177.2 сая төгрөг, ИНҮТ аппарат 87.2 сая төгрөг, АЗЗАН Баянчандмань салбар 49.4 сая төгрөг, АЗЗАН Увс салбар 24.2 сая төгрөг, АЗЗАН Завхан салбар 24.1 сая төгрөг, АЗННС 9.6 сая төгрөг, ХХНОБ ТӨХХК 8.2 сая төгрөг, Шивээ хүрэн төмөр зам ХХК 8.0 сая төгрөг, АЗЗАН Төв салбар 2.5 сая төгрөг, АЗЗАН Багануур салбар 2.4 сая төгрөг/;

Зам, тээврийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын тайлан

- Шатахуун зарцуулалтын тооцоо хийгээгүй /МИАТ ТӨХК 183.2 сая төгрөг, АЗЗАН Эрдэнэсант салбар 26.9 сая төгрөг, АЗЗАН Налайх салбар 14.3 сая төгрөг, АХОЗШША 10.0 сая төгрөг/
- Татварын хяналт шалгалтаар АЗЗАН Налайх салбар 350.5 сая төгрөг, АЗЗАН Багануур салбар 55.5 сая төгрөгийн торгууль, алданги төлсөн;
- Анхан шатны бүрдэл дутуу баримтаар гүйлгээ хийсэн /АЗЗАН аппарат 428.3 сая төгрөг, МТЗ ТӨХК 50.2 сая төгрөг, АЗЗАН Эрдэнэсант салбар 39.9 сая төгрөг, АЗЗАН Увс салбар 14.0 сая төгрөг/.

3.4.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 388,066.7 сая төгрөг болж, өмнөх оноос 138,522.2 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 3. Авлага дансны үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/ Өсөлт (+) Бууралт (-)
Ажиллагчидтай холбогдсон авлага	51.6	38.2	-13.4
Төлбөртэй үйлчилгээний авлага	26,007.0	29,044.3	3,037.3
Татаас, санхүүжилтийн авлага	5,209.8	0.0	-5,209.8
Дансны авлага /ТӨҮГ/	85,673.4	111,138.3	25,464.9
Татвар, НДШ-ийн авлага	43,446.5	134,628.8	91,182.3
Бусад авлага	89,156.2	113,217.1	24,060.9
Дүн	249,544.5	388,066.7	138,522.2

Эх сурвалж: Зам, тээврийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Авлагын дансны үлдэгдэлд ажиллагсадтай холбоотой 38.2 сая төгрөгийн, төлбөртэй үйлчилгээний 29,044.3 сая төгрөгийн, дансны 111,138.3 сая төгрөгийн, татвар, НДШ-ийн 134,628.8 сая төгрөгийн, бусад 113,217.1 сая төгрөгийн авлага тус тус бүртгэлтэй байна.

Авлагын данс 138,522.2 сая төгрөгөөр өссөн нь дараах шалтгаантай байна. Үүнд:

- МТЗ ТӨХК: Хойшлогдсон НӨАТ-ын авлага, татварын алданги 50,953.4 сая төгрөгөөр, Багахангай-Хөшигийн хөндийн төслийн хойшлогдсон НӨАТ-ын авлага 22,429.5 сая төгрөгөөр, дансны авлага 4,878.4 сая төгрөгөөр, шүүхийн шатны авлага 2,626.2 сая төгрөгөөр, ажиллагсадтай холбоотой авлага 164.3 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн;
- МИАТ ТӨХК: Агаарын хөлгийн шатахууны 14,171.9 сая төгрөгийн НӨАТ, нисэх буудлын үйлчилгээний 19,386.3 сая төгрөгийн НӨАТ-ын авлагыг нэмж бүртгэсэн;
- АЗЗАН ТӨХК: УАЗС-гаас гүйцэтгэсэн ажлын санхүүжилтийн авлага 12,216.0 сая төгрөгөөр, байгууллагын дотоод тооцооны авлага 6,803.8 сая төгрөгөөр, татварын авлага 670.7 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн;
- УАЗС: Байгууллагын авлага 3,752.3 сая төгрөгөөр, төлбөр хураах цэгийн ажилчидтай холбоотой авлага 22.2 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн;
- ЗТХТ ТӨҮГ: МТЗ ТӨХК-ийн гэрээний үлдэгдэл төлбөр 1,654.7 сая төгрөгийн борлуулалтын авлага үүссэн нь голлон нөлөөлсөн байна.

Аудитын илрүүлэлт:

- Авлагыг тооцоо нийлж, баталгаажуулаагүй /МИАТ ТӨХК 14,656.8 сая төгрөг, МТЗ ТӨХК 4,237.9 сая төгрөг, ИНҮТ ТӨХХК 1,363.5 сая төгрөг, ЗТХТ ТӨҮГ 749.4 сая төгрөг, АЗЗАН Орхон салбар 678.4 сая төгрөг, ИНЕГ 433.1 сая төгрөг, УАЗС 370.8 сая төгрөг, АЗЗАН Дархан салбар 93.0 сая төгрөг, АЗЗАН Сэлэнгэ салбар 65.3 сая төгрөг/;
- Он удаан жил болсон авлагыг барагдуулаагүй /МИАТ ТӨХК 5,783.9 сая төгрөг, ИНҮТ ТӨХХК 1,795.5 сая төгрөг, АЗЗАН аппарат 1,736.0 сая төгрөг, ЗТЯ-ны хөрөнгө оруулалт 371.9 сая төгрөг, УАЗС 350.7 сая төгрөг, ИНЕГ 287.7 сая төгрөг, МУДЗ 117.2 сая төгрөг/.

3.4.3 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны эцсийн үлдэгдэл 75,705.7 сая төгрөг болж, өмнөх оноос 3,967.2 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 4. Урьдчилгаа дансны үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+) Бууралт (-)
Урьдчилж гарсан зардал	71,735.5	75,705.7	3,970.2
Урьдчилгаа тооцоо	3.0	0.0	-3.0
Дүн	71,738.5	75,705.7	3,967.2

Эх сурвалж: Зам, тээврийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Урьдчилгаа дансны үлдэгдэлд урьдчилж гарсан зардал 75,705.7 сая төгрөг бүртгэлтэй байна.

Урьдчилгаа дансны үлдэгдэл 3,970.2 сая төгрөгөөр нэмэгдсэн нь МТЗ ТӨХК Багахангай–Хөшигийн хөндийн төслийн гүйцэтгэлийн хэрэгжээгүй НӨАТ-ын төлбөр 14,677.3 сая төгрөг, шүүхийн шийдвэрийн дагуу Тавантолгой–Зүүнбаян төслийн гүйцэтгэлийн төлбөр 2,771.0 сая төгрөгийг урьдчилж төлсөн нь голлон нөлөөлсөн байна.

Аудитын илрүүлэлт:

- УАЗС: Ажил гүйцэтгэгч 4 байгууллагатай байгуулсан гэрээний урьдчилгаа төлбөр 4,398.3 сая төгрөгийг гэрээнд заасан хугацаанд суутгаагүй, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний суутгаагүй үлдсэн урьдчилгаа 141.0 сая төгрөгийг өөр ажлын гэрээний үлдэгдлээс суутгасан, 2020 онд гүйцэтгэсэн ажлын 775.2 сая төгрөгийн хөрөнгийг эрх бүхий байгууллагад хандан шийдвэрлүүлээгүй.

3.4.4 Бараа материал

Бараа материалын дансны үлдэгдэл 127,697.5 сая төгрөг болж, 25,507.9 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 5. Бараа материал дансны үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+) Бууралт (-)
Түүхий эд материал	55,342.1	57,339.9	1,997.8
Дуусаагүй үйлдвэрлэл	1,880.3	719.6	-1,160.7
Бэлэн бүтээгдэхүүн	652.3	5,050.4	4,398.1
Хангамжийн материал	44,272.9	64,564.6	20,291.7
Мал амьтад	42.0	23.0	-19.0
Дүн	102,189.6	127,697.5	25,507.9

Эх сурвалж: Зам, тээврийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бараа материалын дансанд 57,339.9 сая төгрөгийн түүхий эд материал, 719.6 сая төгрөгийн дуусаагүй үйлдвэрлэл, 5,050.4 сая төгрөгийн бэлэн бүтээгдэхүүн, 64,564.6 сая төгрөгийн хангамжийн материал, 23.0 сая төгрөгийн мал амьтад бүртгэлтэй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 25,507.9 сая төгрөгөөр өссөн нь

- МИАТ ТӨХК: Нислэгийн аюулгүй байдал, хэвийн явуулах үндсэн шаардлагын улмаас 2,565.3 сая төгрөгийн агаарын хөлгийн багаж хэрэгсэл, сэлбэг болон 10,191.2 сая төгрөгийн агаарын хөлгийн түлш бэлтгэсэн;
- МТЗ ТӨХК: Тавантолгой – Зүүнбаян төслийн үлдэгдэл 3,181.4 сая төгрөгийн бараа материалыг бүртгэж авсан, үйл ажиллагаанд ашиглахаар 6,447.2 сая төгрөгийн материалын нөөц бүрдүүлснээс шалтгаалсан байна.

Аудитын илрүүлэлт:

Зам, тээврийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын тайлан

- МИАТ ТӨХК: Ашиглалтын хугацаа дууссан 6665 ширхэг 27.9 сая төгрөгийн ликёр үлдэгдэлтэй, 10-аас дээш жилийн насжилттай 17 нэр төрлийн 114.5 сая төгрөгийн, 5-10 жилийн насжилттай 18 төрлийн 42.4 сая төгрөгийн ашиглалтгүй бараа материалын нөөц үүсгэсэн;
- Анхан шатны баримт, гарын үсгийн бүрдэл дутуу, үлдэгдлийг зөрүүтэй тайлагнасан, бараа материалыг бөөн дүнгээр зарлагасан /МТЗ ТӨХК 166.9 сая төгрөг, Шивээр хүрэн төмөр зам ХХК 13.8 сая төгрөг, АТҮТ Завхан салбар, Орхон салбар/.

3.4.5 Бусад эргэлтийн хөрөнгө

Бусад эргэлтийн хөрөнгийн дансны үлдэгдэл 1,605,227.0 сая төгрөг болж, 470,814.9 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 6. Бусад эргэлтийн хөрөнгө дансны үлдэгдэл /сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+) Бууралт (-)
Бусад эргэлтийн хөрөнгө	1,134,375.6	1,605,227.0	470,851.4
Борлуулах зорилгоор эзэмшиж буй эргэлтийн хөрөнгө	36.5	0.0	36.5
Дүн	1,134,412.1	1,605,227.0	470,814.9

Эх сурвалж: Зам, тээврийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Бусад эргэлтийн хөрөнгө дансны үлдэгдэл 470,814.9 сая төгрөгөөр өссөн нь улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн 470,565.8 сая төгрөгийн төсөл, арга хэмжээг бусад эргэлтийн хөрөнгөнд бүртгэсэнтэй холбоотой байна.

Аудитын илрүүлэлт:

- УАЗС: Бусад эргэлтийн бус хөрөнгөнд бүртгэлтэй, 2020-2023 онд гүйцэтгэсэн 9 ажлын 1,092.3 сая төгрөгийн хөрөнгийг эрх бүхий байгууллагад хандан шийдвэрлүүлээгүй;
- ЗТЯ-ны хөрөнгө оруулалт: Дуусаагүй үйлдвэрлэл дансанд 2017-2022 онд гүйцэтгэсэн 48 ажлын 115,559.9 сая төгрөгийн замын ажлыг ашиглагч байгууллагын эзэмшилд шилжүүлээгүй.

3.4.6 Урт хугацаат хөрөнгө оруулалт

Урт хугацаат хөрөнгө оруулалтын дансны үлдэгдэл 48,652.9 сая төгрөг болж, 693,764.2 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 7. Урт хугацаат хөрөнгө оруулалтын дансны үлдэгдэл /сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+) Бууралт (-)
Үнэт цаас	693,765.7	1.5	-693,764.2
Урт хугацаат зээл	48,651.4	48,651.4	0.0
Дүн	742,417.1	48,652.9	-693,764.2

Эх сурвалж: Зам, тээврийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Урт хугацаат хөрөнгө оруулалтын дансны үлдэгдэл 693,764.2 сая төгрөгөөр буурсан нь Засгийн газрын 2025 оны “Эрдэнэс Тавантолгой ХК, Монголын төмөр зам ТӨХК-ийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 65 дугаар тогтоол, Монголын төмөр зам ТӨХК-ийн ТҮЗ-ийн 2025 оны “Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 65 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх тухай” 04 дүгээр тогтоолын дагуу Монголын төмөр зам ТӨХК-ийн эзэмшиж байгаа Тавантолгой төмөр зам ХХК-ийн нэг бүр нь 2500 төгрөгийн үнэ бүхий 277,505,246 ширхэг нийт 693,763.1 сая төгрөгийн 34.0 хувийн хувьцааг МТЗ ТӨХК-ийн гаргасан 750,000.0 сая төгрөгийн бондоос суутган тооцох замаар “Эрдэнэс Тавантолгой” ХК-д шилжүүлсэнтэй холбоотой байна.

3.4.7 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 6,601,670.2 сая төгрөг болж, 94,145.7 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 8. Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/ Өсөлт (+) Бууралт (-)
Барилга, байгууламж, орон сууц	1,208,527.9	2,286,192.9	1,077,665.0
Авто тээврийн хэрэгсэл	108,045.0	114,587.1	6,542.1
Машин тоног төхөөрөмж	230,820.3	202,650.9	-28,169.4
Тавилга, эд хогшил	5,866.6	4,573.0	-1,293.6
Зам, гүүрийн байгууламж	2,502,597.4	2,128,755.7	-373,841.7
Бусад үндсэн хөрөнгө	113,850.7	167,662.8	53,812.1
Дуусаагүй барилга, байгууламж	1,411,950.7	646,762.5	-765,188.2
Биет бус хөрөнгө	1,080,633.1	532,324.9	-548,308.2
Бусад хөрөнгө	33,524.2	518,160.4	484,636.2
Дүн	6,695,815.9	6,601,670.2	-94,145.7

Эх сурвалж: Зам, тээврийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл буурсан нь дараах байгууллагуудын үндсэн хөрөнгийн хөдөлгөөний өөрчлөлтүүд нөлөөлсөн байна. Үүнд:

- ИНЕГ: ТӨБЗГ-ын 2025 оны 677 дугаар тогтоолоор 677.7 сая төгрөгийн хөрөнгийг АХОЗШША-нд балансаас баланст шилжүүлсэн, 29,773.8 сая төгрөгийн хөрөнгийг шинээр бэлтгэж, балансаас баланст шилжүүлэн авсан;
- МИАТ ТӨХК: Агаарын JU-1021 хөлөгт 1,639.2 сая төгрөгийн хөдөлгүүр, барилга байгууламжид 6,355.1 сая төгрөгийн хөрөнгө оруулалтыг хийж, үндсэн хөрөнгөд 21,606.0 сая төгрөгийн элэгдэл, түрээсийн 9 агаарын хөлгийн хөрөнгө ашиглах эрхэд 70,372.8 сая төгрөгийн хорогдол байгуулсан;
- МТЗ ТӨХК: ТӨБЗГ-ын 2025 оны 797 дугаар тогтоолоор Зүүнбаян–Цогтцэций төмөр замын төслийн 1,200,522.6 сая төгрөгийн хөрөнгийг дуусаагүй барилга байгууламжийн данснаас шилжүүлэн бүртгэсэн, Зүүнбаян–Цогтцэций төмөр зам дагуу барьж байгуулсан 11,124.2 сая төгрөгийн 219 км урттай төмөр замын хориг хашаа зэрэг нийт 1,211,646.8 сая төгрөгийн хөрөнгө, 935.3 сая төгрөгийн 10 автомашин, 729.7 сая төгрөгийн иж бүрэн суурин компьютер, принтер, бусад дагалдах хэрэгсэл, 176.7 сая төгрөгийн тавилга эд хогшил, 85.2 сая төгрөгийн хүний нөөц, төмөр замын тээврийн программ хангамжийг тус тус худалдан авсан. ЗТЯ-аас 169.0 сая төгрөгийн 1 автомашиныг шилжүүлэн авч, 49 хоппер вагон, 4 зүтгүүрийг засвар үйлчилгээнд оруулж 22,417.3 сая төгрөгөөр капиталжуулсан нь голлон нөлөөлсөн байна.

Аудитын илрүүлэлт:

- ИНҮТ ТӨХХК: 71.6 сая төгрөгийн 3 газар эзэмших эрхийн гэрчилгээгүй, 1,228.1 сая төгрөгийн 8 газар кадастрын зураггүй, 41.0 сая төгрөгийн 3 газар газрын эзэмших эрхийн хугацаа дууссан, 3,412.1 сая төгрөгийн 2 газар гэрчилгээ, кадастрын зургийн талбайн хэмжээ зөрүүтэй байна. Нийт 4,349.8 сая төгрөгийн балансын үнэ бүхий 86 тээврийн хэрэгсэл тээврийн хэрэгслийн гэрчилгээгүй, эзэмшигч тодорхойгүй, ИНЕГ болон бусад байгууллагын нэр дээр бүртгэлтэй 70 тээврийн хэрэгслийн гэрчилгээг шилжүүлж аваагүй;
- ИНЕГ: Үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээгүй, ашиглалтгүй байгаа нийт 449.5 сая төгрөгийн үлдэх өртөгтэй, өвлийн 2 давхар 7 ширхэг байшинг эрх бүхий байгууллагад хандаж шийдвэрлүүлээгүй, 15.1 сая төгрөгийн үлдэх өртөгтэй 16 кв.м 1 өрөө орон сууц, 139.5 сая төгрөгийн үлдэх өртөгтэй тээврийн хэрэгслийн гэрчилгээ иргэн болон бусад байгууллагын нэр дээр бүртгэлтэй;

Зам, тээврийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын тайлан

- ЗТЯ: Санхүүгийн тайланд бүртгэлгүй 14 байршилд байрлалтай газрын төлбөрт 7.8 сая төгрөгийг төлсөн бөгөөд газрыг үнэлж, бүртгэлд тусгаагүй;
- УАЗС: Бусад эргэлтийн бус хөрөнгөнд бүртгэлтэй, 2020-2023 онд гүйцэтгэсэн 9 ажлын 1,092.3 сая төгрөгийн хөрөнгийг эрх бүхий байгууллагад хандан шийдвэрлүүлээгүй үлдэгдэлтэй;
- МИАТ ТӨХК: 12.0 сая төгрөгийн үнэ бүхий 2 зөөврийн компьютерыг ажлаас чөлөөлөгдсөн ажилтнаас хүлээж аваагүй;
- АЗЗАН Дорноговь салбар: Үндсэн хөрөнгийн дансанд автогрейдэр, приус-30, портер-2, ланд-200 маркийн тээврийн хэрэгслийг бүртгээгүй;
- ТАЦ: Төлбөр хураах 7 цэгт 21.3 сая төгрөгөөр худалдан авсан хөрөнгийг данс бүртгэлд бүртгээгүй;
- Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгийн үлдэгдлийн хэрэгцээ, шаардлагыг тодорхойлж, ашиглалтын хугацаа, үнийг шинэчлэн тогтоох болон данснаас хасах асуудлыг эрх бүхий байгууллагад хандаж шийдвэрлүүлээгүй /МИАТ ТӨХК 10,546.1 сая төгрөг, АЗЗАН Дорноговь салбар 888.9 сая төгрөг, ЗТХТ ТӨҮГ 1,756.7 сая төгрөг, МУДЗ 424.8 сая төгрөг, ТЗГ 115.0 сая төгрөг, АТҮТ Сэлэнгэ салбар 55.0 сая төгрөг, МТЗ ТӨХК 1537 ширхэг хөрөнгө/.

3.4.8 Өр төлбөр

Өр төлбөр дансны үлдэгдэл 2,537,309.0 сая төгрөг болж, 306,115.4 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 9. Өр төлбөр дансны үлдэгдэл

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/сая төгрөгөөр/
			Өсөлт (+) Бууралт (-)
Богино хугацаат өр төлбөр	510,081.2	918,237.8	408,156.6
Богино хугацаат зээлийн өглөг	38,030.0	26,824.9	-11,205.1
Өглөг	275,850.0	746,686.9	470,836.9
Урьдчилж орсон орлого	196,201.2	144,726.0	-51,475.2
Урт хугацаат өр төлбөр	2,333,343.2	1,619,071.2	-714,272.0
Урт хугацаат үнэт цаас	1,475,504.6	870,268.1	-605,236.5
Урт хугацаат зээл	857,838.6	748,803.1	-109,035.5
Дүн	2,843,424.4	2,537,309.0	-306,115.4

Эх сурвалж: Зам, тээврийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Богино хугацаат өр төлбөрийн дансны үлдэгдэл 408,156.6 сая төгрөгөөр өссөн нь

- МТЗ ТӨХК: Багахангай – Хөшигийн хөндий төслийн хянан баталгаажуулсан гэрээт ажлын өглөг 141,904.2 сая төгрөгөөр, бондын өглөг 120,500.0 сая төгрөгөөр, Багахангай – Хөшигийн хөндий чиглэлийн салбар төмөр замын төслийн хүрээнд санхүүжүүлсэн Тавантолгой төмөр зам ХХК-ийн өглөг 77,370.4 сая төгрөгөөр, Сангийн яамтай байгуулсан дамжуулан зээлдүүлэх зээлийн хүүгийн өр төлбөр 10,378.3 сая төгрөгөөр, бондын хүүгийн өглөг 6,014.3 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн;
- МИАТ ТӨХК: Тийзийн борлуулалт болон нисэх буудлуудын зорчигч үйлчилгээний хураамж 26,094.7 сая төгрөгөөр өсөж, өглөг үүссэн;
- ЗТЯ-ны хөрөнгө оруулалт: Хөрөнгийн барьцаа 103,246.5 сая төгрөгийг чөлөөлсөн.

Урт хугацаат өр төлбөр дансны үлдэгдэл 714,272.0 сая төгрөгөөр буурсан нь

- МТЗ ТӨХК: Урт хугацаат хөрөнгө оруулалтын данс 693,764.2 сая төгрөгөөр буурсан;
- МИАТ ТӨХК: Хаан банкны 2027 оны 1 дүгээр сард төлөх эргэлтийн хөрөнгийн зээлийн 19,399.9 сая төгрөгийн үндсэн төлбөр болон түрээсийн 9 агаарын хөлгийн төлбөрийг богино хугацаат түрээсийн өглөг рүү бууруулан бүртгэсэнтэй холбоотой байна.

Аудитын илрүүлэлт:

Зам, тээврийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын тайлан

- Өглөгийг тооцоо нийлж, баталгаажуулаагүй /МТЗ ТӨХК 26,302.6 сая төгрөг, ИНҮТ ТӨХХК 3,482.0 сая төгрөг, МИАТ ТӨХК 1,787.8 сая төгрөг, ИНЕГ 933.4 сая төгрөг, УАЗС 605.3 сая төгрөг, АЗЗАН Орхон салбар 373.7 сая төгрөг, АЗННС 376.7 сая төгрөг, АЗЗАН Дархан салбар 66.6 сая төгрөг/;
- Олон жилийн насжилттай өглөгийн үлдэгдэлтэй, өр төлбөрийг бууруулах арга хэмжээ зохион байгуулаагүй /ИНЕГ 1,579.9 сая төгрөг, АЗЗАН аппарат 1,179.2 сая төгрөг, АЗННС 1,026.3 сая төгрөг/
- Хөрөнгө оруулалтын барьцаа дансанд 2018-2020 онд хэрэгжиж, хөөн хэлэлцэх хугацаа дууссан 13 гүйцэтгэгч байгууллагын 434.3 сая төгрөгийн үлдэгдлийг шийдвэрлээгүй;
- Эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр санхүүжилтийг нөхөх зорилгоор иргэн, хуулийн этгээдээс хүүтэй зээл авсан /АЗЗАН Баянчандмань, АЗЗАН Орхон, АЗЗАН Эрдэнэсант/
- ЗТХТ ТӨҮГ: Өр төлбөрийн дансны үлдэгдлийг 357.2 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан;
- ТАЦ: Өмнөх оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд туссан ажлын гэрээг нэр бүхий 1 компанитай байгуулж, гэрээт ажлын төлбөр 104.5 сая төгрөгийг өөр байгууллагад өглөг үүсгэж олгосон.

3.4.9 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 6,541,419.4 сая төгрөг болж 28,861.0 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 10. Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл

Үзүүлэлт	/сая төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+) Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал	2,172,015.6	1,723,481.7	-448,533.9
Өмч /төрийн/	94,446.4	545,075.4	450,629.0
Өмч /хувийн/	0.5	0.5	0.0
Нэмж төлөгдсөн капитал	32.6	32.6	0.0
Эздийн өмчийн бусад хэсэг	945,126.0	958,075.5	12,949.5
Хуримтлагдсан үр дүн	1,042,633.3	1,061,725.9	19,092.6
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,257,974.3	2,252,641.8	-5,332.5
Бодлогын өөрчлөлт алдааны залруулга	216.3	272.6	56.3
Хяналтын бус хувь оролцоо	113.4	113.4	0.0
Дүн	6,512,558.4	6,541,419.4	28,861.0

Эх сурвалж: Зам, тээврийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 28,861.0 сая төгрөгөөр өссөн нь

- ИНЕГ Засгийн газрын 2024 оны 189 дүгээр тогтоолоор засгийн газрын тохируулагч агентлаг, ИНҮТ Засгийн газрын 2024 оны 193 дугаар тогтоолоор ТӨХХК болгон өөрчлөн зохион байгуулагдаж, ИНЕГ-ын засгийн газрын оруулсан капитал 448,533.9 сая төгрөгөөр буурч, ИНҮТ ТӨХХК-ийн төрийн өмч 445,541.8 сая төгрөгөөр өссөн;
- Эздийн өмчийн бусад хэсэг 12,949.5 сая төгрөгөөр өссөн нь МТЗ ТӨХК ТӨБЗГ-ын 2025 оны А-1/1764 дугаар зөвшөөрлөөр 13,303.4 сая төгрөгийн газрын үнэлгээ, 38,172.7 сая төгрөгийн цэвэр ашиг тус тус бүртгэсэн;
- Хуримтлагдсан үр дүнгийн данс 19,092.6 сая төгрөгөөр өссөн тайлант оны үр дүнгээс шалтгаалсан байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Зам, тээврийн сайд нь 2025 оны төсвийн төсөлд 4 хөтөлбөрийн 10 арга хэмжээг санхүүжүүлэхэд урсгал зардлыг 41,959.0 сая төгрөгөөр, хөрөнгийн зардлыг 2,147,475.5 сая төгрөгөөр, улсын төсөвт төвлөрүүлэх орлогын хэмжээг 26,000.0 сая төгрөгөөр тус тус төлөвлөж, Сангийн сайдад хүргүүлсэн байна. Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс урсгал зардлыг 17,596.2 сая төгрөгөөр, хөрөнгийн зардлыг 1,258,869.2 сая төгрөгөөр тус тус бууруулж, нийт зардлыг 1,091,171.8 сая төгрөгөөр, улсын төсөвт төвлөрүүлэх орлогын хэмжээг 84,656.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж, нийт төвлөрүүлэх орлогыг 110,656.0 сая төгрөгөөр баталжээ.

Тайлант онд Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт орж, урсгал санхүүжилтийг 1,732.1 сая төгрөгөөр, хөрөнгийн зардлыг 75,937.7 сая төгрөгөөр тус тус бууруулж, нийт зардлыг 1,013,502.0 сая төгрөгөөр, улсын төсөвт төвлөрүүлэх орлогын хэмжээнд өөрчлөлт оруулаагүй баталсан байна. Үүнд: УАЗС-гийн зардлыг 42,795.0 сая төгрөгөөр, ЗТЯ-ны хөрөнгө оруулалтыг 33,142.8 сая төгрөгөөр, урсгал зардлыг 1,221.7 сая төгрөгөөр, ИНЕГ-ын урсгал зардлыг 430.6 сая төгрөгөөр, Төмөр замын газрын урсгал зардлыг 79.7 сая төгрөгөөр тус тус бууруулсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Улсын төсвийн орлого бүрдүүлэлт

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулиар 110,656.0 сая төгрөгийн орлогын төлөвлөгөө батлагдсанаас төлөвлөгөөг бүрэн хэрэгжүүлж, улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 11. Улсын төсвийн орлого бүрдүүлэлт /сая төгрөгөөр/

д/д	Орлогын нэр төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	Навигацийн орлого /ИНЕГ/	80,000.0	80,000.0	0.0	100.0
2	Хөлөг онгоцны бүртгэлийн орлого /МУДЗ/	300.0	300.0	0.0	100.0
3	Төлбөр авах цэгийн орлого /УАЗС/	25,356.0	25,356.0	0.0	100.0
	Нийт дүн	105,656.0	105,656.0	0.0	100.0

Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн зарцуулалт

Тайлант онд гүйцэтгэлээр улсын төсвөөс 765,739.3 сая төгрөгийн санхүүжилтийг авч, 3,873.9 сая төгрөгийг улсыг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 761,865.4 сая төгрөг буюу 75.2 хувьтай байна. Энэ нь хөрөнгийн зардлыг 250,025.5 сая төгрөгөөр, урсгал шилжүүлгийг 817.6 сая төгрөгөөр, татаасыг 470.2 сая төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 12. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл /сая төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	80101 Үндсэн үйл ажиллагааны зардал	12,356.9	12,033.6	323.3	97.4
2	80205 Мэдээлэл, сурталчилгааны зардал	17.8	17.8	0.0	100.0
3	80226 Байр ашиглалтын үйлчилгээ	433.1	433.1	0.0	100.0
4	80404 Хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас	2,893.0	2,422.8	470.2	83.7
5	80509 ОУ-ын байгууллагын гишүүнчлэл хураамж	210.8	0.0	210.8	-
6	80704 Ахмад дайчин, алдар цолтой ахмад настанд үзүүлэх хөнгөлөлт тусламж	288.6	286.4	2.2	99.2
7	80802 Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	955.6	351.0	604.6	36.7
8	80918 Бусад	990,871.2	740,845.7	250,025.5	74.8
9	Төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх	5,475.0	5,475.0	0.0	100.0
	Нийт дүн	1,013,502.0	761,865.4	251,636.6	75.2

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан “Төрийн аудитын байгууллагаас төсвийн тухай хуулийн дагуу 2025-2026 онд гүйцэтгэх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах чиглэл”-ийн дагуу Зам, тээврийн сайдын эрхлэх асуудлын хүрээний 13¹ байгууллагаас судалгаа авч, үр дүнг² тусгалаа. Үүнд:

- *Хоол, унааны хөнгөлөлтийн талаар:* Нийт 13 байгууллага албан хаагчдын унаа, хоолны зардалд 27,892.1 сая төгрөгийг төлөвлөснөөс гүйцэтгэлээр 27,514.0 сая төгрөгийг олгосон байна. Унаа, хоолны зардал өмнөх оноос 4,869.2 сая төгрөгөөр өссөн бөгөөд хоолны мөнгийг 6.0-50.0 мянган төгрөг, унааны зардлыг 3.0-5.0 мянган төгрөгөөр тогтоожээ. Иргэний нисэхийн салбар унааны мөнгийг олголгүйгээр ажилчдын унаагаар үйлчилдэг байна.
- *Гадаад томилолтын талаар:* Нийт 9 байгууллага 13,397.2 сая төгрөгийн 529 гадаад томилолтын арга хэмжээг төлөвлөж, гүйцэтгэлээр 462 арга хэмжээнд 9,619.0 сая төгрөгийг зарцуулсан байна. Аудитаар гадаад болон дотоод албан томилолтын зардалтай холбоотой гадаад арга хэмжээний төлөвлөгөөнд тусгаагүй, эрх бүхий байгууллагын тушаал шийдвэр удирдамжгүй, анхан шатны баримтын бүрдэл дутуу, бусад байгууллагын албан хаагчдад томилолтын зардал олгосон зэрэг нийт 648.0 сая төгрөгийн 28 зөрчил илэрснээс 83.5 сая төгрөгийн 10 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 455.0 сая төгрөгийн 8 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 109.5 сая төгрөгийн 10 зөрчилд зөвлөмж өгсөн.
- *Программ хангамжийн талаар:* Нийт 13 байгууллагын санхүүгийн тайланд 22,029.2 сая төгрөгийн 201 программ, лиценз бүртгэлтэйгээс тайлант онд урсгал төсвөөс 3.1 сая төгрөг, хөрөнгө оруулалтын зардлын төсвөөс 128.7 сая төгрөгийг программ хөгжүүлэлтэд зарцуулсан байна. Нийт программ, лицензийн 18,799.1 сая төгрөгийн 153 программ байгууллагын үндсэн үйл ажиллагаанд, 2,815.5 сая төгрөгийн 27 программ санхүүгийн үйл ажиллагаанд, 378.2 сая төгрөгийн 17 программ албан хэрэгцээнд ашиглагдаж байна. Нийт 36.4 сая төгрөгийн 1 программ, лицензийн болон судалгааны хугацаа дууссан, үйл ажиллагааны системд таарахгүй болсон зэргээс шалтгаалж ашиглагдахгүй байна.
- *Сургалт, семинар, хурал, зөвлөгөөний талаар:* Нийт 10 байгууллага 6,005.6 сая төгрөгийн 488 сургалт семинар зохион байгуулахаар төлөвлөж, гүйцэтгэлээр 2,793.9 сая төгрөгийн 344 сургалтыг зохион байгуулсан, нийт 6 байгууллага хурал, зөвлөгөөн, түүнтэй адилтгах 270.8 сая төгрөгийн 62 арга хэмжээг төлөвлөж, гүйцэтгэлээр 176.4 сая төгрөгийн 38 арга хэмжээг зохион байгуулсан байна. Аудитаар төлөвлөгөөнд тусгаагүй сургалт зохион байгуулсан, хөрөнгийг арвилан хэмнэлтгүй зарцуулсан зэрэг нийт 40.8 сая төгрөгийн 3 зөрчил илэрснээс 0.6 сая төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 38.8 сая төгрөгийн 1 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 1.5 сая төгрөгийн 1 зөрчилд зөвлөмж өгсөн.
- *Орон тооны талаар:* Нийт 11 байгууллагын 6467 албан хаагчийн цалингийн зардалд 271,965.7 сая төгрөгийг баталсан байна. Тодотголоор орон тоог 273-аар, цалингийн зардлыг 31,666.3 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 303,632.0 сая төгрөгөөр өөрчлөн баталжээ. Гүйцэтгэлээр 6915 албан хаагчид 309,029.0 сая төгрөгийг олгосон байна. Төрийн албаны чиг үүргийн давхардлыг арилгах, төрийн албан хаагчийн тоог 9.0 хувиар

¹ Авто Импекс ТӨХК судалгаанд хамрагдаагүй.

² Зам, тээврийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын аудитаар илрүүлсэн зөрчлийг нэгтгэж оруулсан.

бууруулах бодлогын хүрээнд ЗТЯ, ИНЕГ, ИНҮТ ТӨХХК нийт 116 орон тоог бууруулсан бөгөөд үүнээс 13 удирдах албан тушаалтан байна. Тайлант онд МТЗ ТӨХК-д “Тавантолгой төмөр зам” ХХК-ийг нэгтгэснээс бүтцийн өөрчлөлт хийж, 273 орон тоо, ЗТХТ ТӨҮГ-т Багахангай – Хөшигийн хөндий чиглэлийн төмөр замын төслийн техник, технологийн хяналтын ажлыг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор 15 орон тоо, Засгийн газрын 2025 оны Төмөр замын газар байгуулах тухай 73 дугаар тогтоолоор төмөр замын агентлагийг байгуулж, 23 орон тоо тус тус нэмсэн.

- *Хэвлэл, мэдээллийн талаар:* Нийт 7 байгууллага хэвлэл мэдээллийн 95 байгууллагатай 938.8 сая төгрөгийн гэрээ байгуулж гүйцэтгэлээр 847.7 сая төгрөгийг зарцуулсан байна.
- *Төрийн өмчит хуулийн этгээдийн талаар:* Нийт 8 төрийн өмчит хуулийн этгээдийн төрийн өмчийн хувь эзэмшлийг дараах байгууллагууд эзэмшиж байна. Үүнд: ИНҮТ ТӨХХК-ийн 100.0 хувийг Зам, тээврийн сайд, Авто тээврийн үндэсний төв ТӨҮГ, Зам, тээврийн хөгжлийн төв ТӨҮГ-ын 100.0 хувийг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар, Монголын иргэний агаарын тээвэр ТӨХК, Монголын төмөр зам ТӨХК, Авто замын засвар арчлалтын нэгтгэл ТӨХК-ийн 100.0 хувийг Эрчист Монгол ХХК, Хөшигийн хөндийн нисэх онгоцны буудал ТӨХХК-ийн 66.0 хувийг Зам, тээврийн яам, 34.0 хувийг ТӨБЗГ тус тус эзэмшиж байна. Тайлант онд 8 хуулийн этгээдийн эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшнээр 47,927.3 сая төгрөгийн ашигтай ажиллагаа баталсан боловч гүйцэтгэлээр 6 хуулийн этгээд 104,956.1 сая төгрөгийн ашигтай ажиллаж, 3 хуулийн этгээд 36,370.9 сая төгрөгийн алдагдалтай ажилласан;
- *Төрд учирсан хохирлын талаар:* Эрх бүхий албан тушаалтны буруутай шийдвэрээс шалтгаалж ажлаас чөлөөлөгдсөн албан тушаалтанд шүүхийн шийдвэрийн дагуу байгууллагаас нөхөн олговрыг олгоогүй байна.

3.5.3 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Зам, тээврийн сайдын 2024 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн А/294 дүгээр тушаалаар худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг баталж, 2025 оны А/73, А/102 дугаар тушаалаар нэмэлт өөрчлөлт оруулсан байна.

Тайлант онд худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд нийт 263,169.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 83 төсөл арга хэмжээг 93,374.0 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр баталсан байна. Үүнд:

- Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих 50,028.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 42 төсөл арга хэмжээний 11,190.5 сая төгрөг;
- Зээл, тусламжаар хэрэгжих 166,514.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 17 төсөл, арга хэмжээний 35,557.6 сая төгрөг;
- УАЗС-гийн хөрөнгөөр хэрэгжих 41,641.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 13 төсөл, арга хэмжээний 41,641.2 сая төгрөг;
- Урсгал төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих 298.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 5 төсөл, арга хэмжээний 298.6 сая төгрөг;
- Жолоочийн даатгалын сангийн хөрөнгөөр хэрэгжих 4,686.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 6 төсөл, арга хэмжээний 4,686.1 сая төгрөг тус тус байна.

Гүйцэтгэлээр 1,176,305.0 сая төгрөгийн 52 төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, гэрээ байгуулан, худалдан авах ажиллагааны тайланг холбогдох байгууллагад хүргүүлсэн байна. Тайлант онд зээл тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 166,014.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 15 төсөл арга хэмжээ, төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 114,528.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 15 төсөл арга хэмжээ тус тус хэрэгжээгүй байна. Үүнээс 114,438.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 12 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг хуулийн хугацаанд зохион байгуулаагүй байна.

Аудитын илрүүлэлт:

- МТЗ ТӨХК: Худалдан авах ажиллагаа хууль журмын дагуу зохион байгуулаагүй, төсөвт өртгийг хувааж худалдан авалт хийсэн 581.6 сая төгрөг;
- ИНҮТ ТӨХХК: Худалдан авах ажиллагааны хэрэгжилт хангалтгүй, худалдан авах ажиллагааг цахимаар зохион байгуулаагүй 18.9 сая төгрөг;
- АЗЗАН ТӨХК: Нээлттэй сонгон шалгаруулалтаар шалгарсан гүйцэтгэгчдээс гэрээний үнийн дүнгийн 20.0 хувиас илүү худалдан авалт хийсэн 137.3 сая төгрөг, Тендерийн үнэлгээний хорооны зөвлөмжийн дүнг хэтрүүлэн гэрээ байгуулсан 408.5 сая төгрөг, шууд болон харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаарыг мөрдөөгүй шууд давсан худалдан авалт хийсэн 2,147.2 сая төгрөг;
- ИНЕГ: Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг шинэчлэн батлахдаа тайлант онд хэрэгжих боломжгүй төсөл, арга хэмжээг төлөвлөсөн, худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулаагүй 683.5 сая төгрөг;
- ТАЦ: Шууд гэрээ байгуулах зорилгоор төсөвт өртгийг хувааж гэрээ байгуулсан 29.5 сая төгрөгийн зөрчил тус тус илэрсэн.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн аудитаар дараах зөрчил илэрсэн. Үүнд:

Илрүүлэлт 1:

Худалдан авах ажиллагааг зохион байгуулах эрхийг мэргэжлийн байгууллагад хугацаа хоцроож шилжүүлсэн, зарим төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг хуулийн хугацаанд зохион байгуулаагүй байна. Үүнд:

1. Арабын эдийн засгийн хөгжлийн Кувейтийн сангийн буцалтгүй тусламжаар санхүүжүүлэх 888,000.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1 төсөл, арга хэмжээг 3 сараар, жолоочийн даатгалын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх 4,646.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 4 төсөл, арга хэмжээний жагсаалтыг 2 сараар хугацаа хоцроож, шилжүүлсэн.
2. Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн нийт 114,438.7 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 12 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг хуулийн хугацаанд зохион байгуулаагүй. Үүнд: Төрийн худалдан авах ажиллагааны газарт хэрэгжүүлэх 69,966.9 сая төгрөгийн 4 төсөл арга хэмжээ, ЗТЯ болон харьяа газарт хэрэгжүүлэх 44,471.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 8 төсөл, арга хэмжээ байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т "Төсвийн ерөнхийлөн захирагч нь төсөв хуваарилах, зарцуулахтай холбогдсон бүрэн эрхээ төсвийн төвлөрүүлэн захирагч, эсхүл харьяалах төсвийн шууд захирагчид шилжүүлж болох бөгөөд ийнхүү шилжүүлсэн нь түүнийг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.7-д "Төсвийн ерөнхийлөн захирагч тухайн төсвийн жилд хэрэгжүүлэх энэ хуулийн 45.1, 45.2, 45.3, 45.4-т зааснаас бусад төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтыг зохион байгуулах эрхийг харьяалах доод шатны төсвийн захирагчид, эсхүл худалдан авах ажиллагааны мэргэжлийн байгууллагад шилжүүлэхээр шийдвэрлэсэн бол ажлын 10 өдрийн дотор шилжүүлнэ", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1-д "батлагдсан төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг жил бүрийн 05 дугаар сарын 31-ний өдрийн дотор бүрэн дуусгах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулах эрхийг мэргэжлийн байгууллагад хуулиар тогтоосон хугацаанд шилжүүлээгүй, худалдан авах ажиллагааг хуулийн хугацаанд хэрэгжүүлээгүй зөрчлийг таслан зогсоох албан шаардлага хүргүүлсэн.

Илрүүлэлт 2:

Тайлант онд Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт туссан төсөл, арга хэмжээнүүдээс түүвэрлэн шалгахад дараах төсөл арга хэмжээнүүд хэрэгжээгүй байна. Үүнд:

- Худалдан авах ажиллагаа амжилтгүй болсноос Нислэгийн хөдөлгөөний удирдлагын үйлчилгээний дэд бүтцийг шинэчлэн, дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлэх төсөл;
- Шаардлага хангасан тендер ирээгүйгээс Улаанбаатар-Арвайхээр чиглэлийн авто замаас Есөнзүйл сум хүртэлх 16 км хатуу хучилттай авто зам барих төсөл, "Шинэ тойруу" хурдны зам, хөнгөн төмөр замын тээвэр байгуулах төсөл;
- Төсөвт тусгахаар саналаа хүргүүлсэн боловч шийдэгдээгүй Буйр нуур олон улсын иргэний нисэхийн байгууллага (ICAO)-ын "4С" ангилал бүхий нисэх буудал байгуулах төсөл тус тус байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3-т "Төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн эрхлэх асуудлын төсвийн орлого, зарлагын зүй зохистой, үр ашигтай байдал, үр дүнгийн гүйцэтгэлийг хангаж, өөрт хамаарах төсвийн гүйцэтгэлийн биелэлтийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засгийн газар, Улсын Их Хурлын өмнө бүрэн хариуцна.", 27 дугаар зүйлийн 27.1.8-д "Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд суурилсан байх"; Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.7-д "Төсвийн ерөнхийлөн захирагч тухайн төсвийн жилд хэрэгжүүлэх энэ хуулийн 45.1, 45.2, 45.3, 45.4-т зааснаас бусад төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтыг зохион байгуулах эрхийг харьяалах доод шатны төсвийн захирагчид, эсхүл худалдан авах ажиллагааны мэргэжлийн байгууллагад шилжүүлэхээр шийдвэрлэсэн бол ажлын 10 өдрийн дотор шилжүүлнэ" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Хэрэгжүүлэхээр төлөвлөсөн арга хэмжээний санхүүжилтийн эх үүсвэрийг оновчтой зөв төлөвлөх, худалдан авах ажиллагааг хуулийн хугацаанд амжилттай зохион байгуулахад анхаарах зөвлөмж өгсөн.

3.5.4 Хөтөлбөр арга хэмжээний хүрэх үр дүн, хэрэгжилт

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн 1 дүгээр хавсралтаар баталсан "Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2025 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлт"-д Зам, тээврийн сайдын 4 хөтөлбөрийн 10 арга хэмжээг баталсан байна.

Хөтөлбөрийн зорилт, хүрэх үр дүнг 20 шалгуур үзүүлэлтээр үнэлснээс Арцсуурь боомт –ы Шивээхүрэн боомт чиглэлийн баруун босоо 1255 км төмөр замын төслийн ажлыг 10 хувьд хүргэх арга хэмжээ 10.0 хувийн, ашиглалтад оруулах олон улс, улсын болон орон нутгийн чанартай 1,245.6 км авто замын гүйцэтгэл 26.5 хувийн, бусад арга хэмжээ 79.1-196.8 хувийн гүйцэтгэлтэй байна.

3.5.5 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар Засгийн газрын 2025 оны 50, 55, 282 дугаар тогтоолын дагуу Засгийн газрын нөөц сангаас 2,660.8 сая төгрөг, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогоос 51.0 сая төгрөг, Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газраас 90.6 сая төгрөг, өмнөх оны санхүүжилтээс 5,209.8 сая төгрөгийн эх үүсвэрийг тус тус бүрдүүлж, 2,660.8 сая төгрөгийг зориулалт, эрэмбийн дагуу бараа

Зам, тээврийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын тайлан

үйлчилгээний зардлыг санхүүжүүлэхэд зарцуулж, 1,686.4 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлж, албан журмын даатгагчдын холбооны хөрөнгөөр он дамжин хэрэгжүүлэх 3 арга хэмжээний 3,665.0 сая төгрөгийг татаас санхүүжилтийн авлагаар бүртгэсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Зам, тээврийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн төсвийн ерөнхийлөн захирагчийн эрхлэх асуудлын хүрээ, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн санхүүгийн үйл ажиллагааг сайжруулах, байгууллагын хэлбэрийг тодорхой болгох, дунд хугацааны бодлогын баримт бичигт туссан төсөл, арга хэмжээний санхүүжилтийг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх, төсвийн төслийг улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөтэй уялдуулан төлөвлөх, шалгуур үзүүлэлт, хэмжих нэгж, үнэлэх аргачлалыг тодорхой болгох, гүйцэтгэлийг төсөвтэй уялдуулан тайлагнах, төрийн өмчийн оролцоотой компаниудын ашигт ажиллагааг дээшлүүлэх, цалингийн зөрчилтэй асуудлыг шийдвэрлэх, дотоод хяналт, дотоод аудитыг үр нөлөөтэй хэрэгжүүлэх, аудитыг тогтоосон хугацаанд чанартай хийж гүйцэтгэх, хөтөлбөр арга хэмжээ, хүрэх үр дүнгийн зорилтот түвшний үзүүлэлтийг хангаж ажиллахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Ц.Энхжаргал, аудитор Ж.Мөнхбилгүүн нар гүйцэтгэж, үе шатны чанарын хяналтыг аудитын менежер Д.Энхдалай, Тусгай чиг үүргийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Баярсайхан нар тус тус хэрэгжүүлсэн.

Зам, тээврийн сайд нь 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангаа Үндэсний аудитын газарт 2026 оны 4 дүгээр сарын 02-ны өдрийн 03/1527 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБООУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлангийн нийт зардал 1,168,521.2 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 11,685.2 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хуулиар төсвийн ерөнхийлөн захирагч нь албан хаагчдад хэмнэлтийн горимд шилжин ажиллах талаар үүрэг чиглэл өгч, бичиг хэрэг, ашиглалтын зардлыг хэмнэх зэрэг арга хэмжээ авч ажилласан байна.

Аудитаар Зам, тээврийн сайдын эрхлэх асуудлын хүрээний 6 байгууллагад Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой бүтэц орон тоог оновчтой зохион байгуулаагүй, хуулиар хориглосон зардлыг санхүүжүүлсэн зэрэг 309.2 сая төгрөгийн зөрчил

илэрсэнд 300.2 сая төгрөгийн 9 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 9.0 сая төгрөгийн 3 зөрчилд зөвлөмж өгсөн.

4.4 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн нэгтгэсэн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн аудитаар илэрсэн 5 зөрчилд зөвлөмж өгсөн.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар Зам, тээврийн сайдын эрхлэх асуудлын хүрээний 20 байгууллагад шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг бүрэн оруулаагүй, хугацаа хоцроосон зэрэг нийт 161,300.3 сая төгрөгийн 20 зөрчил илэрснээс 155,860.9 сая төгрөгийн зөрчилд 10 албан шаардлага хүргүүлж, 5,100.8 сая төгрөгийн зөрчилд 9 зөвлөмж өгч, 1 албан тушаалтанд хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлсэн.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Илрүүлэлт 1: МУДЗ, АХОЗШША улсын бүртгэлийн гэрчилгээнд "төрийн байгууллага, албан газар" хэлбэрээр бүртгэлтэй боловч улсын төсвөөс санхүүждэггүй, аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар хэлбэрээр үйл ажиллагаагаа явуулан тайлагнаж байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.34-т "төсвийн байгууллага" гэж баталсан төсвийн дагуу төрийн чиг үүрэгт хамаарах ажил, үйлчилгээг хэрэгжүүлдэг, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд заасны дагуу улсын бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад бүртгүүлсэн төрийн болон орон нутгийн өмчит, ашгийн төлөө бус хуулийн этгээдийг", Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 1-т "Төрийн өмчит үйлдвэрийн газраас бусад улсын төсвөөс санхүүждэг хуулийн этгээдийг төрийн байгууллага, албан газар гэнэ.", 15 дугаар зүйлийн 2-т "Өөрт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр өөрийгөө санхүүжүүлэх зарчмаар ажиллаж бие даан иргэний гүйлгээнд ордог хуулийн этгээдийг аж ахуйн тооцоотой үйлдвэрийн газар гэнэ.", 3-т "Өөрт олгогдсон эд хөрөнгийн үндсэн дээр төсвийн хөрөнгөөр санхүүждэг, зөвхөн төрийн хэрэгцээнд зориулсан үйлдвэрлэл, ажил, үйлчилгээ эрхэлдэг хуулийн этгээдийг улсын төсөвт үйлдвэрийн газар гэнэ." гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Байгууллагуудын хэлбэрийг тодорхой болгож, үйл ажиллагааг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэх зөвлөмж өгсөн.

Илрүүлэлт 2: Улсын Их Хурлын 2020 оны "Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай" 23 дугаар тогтоолын хавсралтаар тус салбарт 2021-2025 он, 2022-2025 онуудад хэрэгжүүлэх, санхүүжилтийн эх үүсвэрийг шийдвэрлэх 5 төсөл, арга хэмжээний жагсаалтыг баталсан боловч эх үүсвэрийг шийдвэрлээгүй байна. Үүнд:

- Хэнтий аймгийн Жаргалтхаан сум - Өмнөдэлгэр сум - Рашаан хад - Өглөгчийн хэрэм-Биндэр сум-Баян-Адарга сум-Дадал сум чиглэлийн 290 км хатуу хучилттай автозам төслийн Биндэр сумаас Дадал сум хүртэлх хатуу хучилттай зам;

- Ховд – Өлгий чиглэлийн автозамаас Ховд, Эрдэнэбүрэн сум хүртэлх, Алтай – Ховд чиглэлийн автозамаас Чандмань сум, Хөшөөтийн уурхай хүртэлх, Мянгад – Дөргөн чиглэлийн автозамаас Дөргөн сум хүртэлх нийт 160 км хатуу хучилттай автозам төслийн барилгын ажил тус тус байна.

Энэ нь Монгол Улсын Их Хурлын 2020 оны "Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай" 23 дугаар тогтоолын 2-т "Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан төсөл, арга хэмжээний санхүүжилтийг тухайн жилийн улсын төсөвт тусгаж байхыг ... " гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Тус салбарт хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний санхүүжилтийн эх үүсвэрийг холбогдох хууль, тогтоомжид нийцүүлэн хуулиар тогтоосон хугацаанд шийдвэрлэх зөвлөмж өгсөн.

Илрүүлэлт 3: Монгол Улсын 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан төсөл, арга хэмжээнүүд Монгол Улсын 2025 оны жилийн төлөвлөгөө, тайлант онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалттай уялдаагүй, гүйцэтгэлийг төсөвт өртөгтэй холбон тайлагнадаггүй, шалгуур үзүүлэлт, хэмжих нэгж тодорхой бус, үнэлэх аргачлал ойлгомжгүйгээс тухайн төслийн гүйцэтгэлийг бодитой үнэлэх, төсөл, арга хэмжээ сунжрах, хэрэгжихгүй байх эрсдэлтэй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3-т "Төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн эрхлэх асуудлын төсвийн орлого, зарлагын зүй зохистой, үр ашигтай байдал, үр дүнгийн гүйцэтгэлийг хангаж, өөрт хамаарах төсвийн гүйцэтгэлийн биелэлтийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засгийн газар, Улсын Их Хурлын өмнө бүрэн хариуцна.", 27 дугаар зүйлийн 27.1.8-д "Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд суурилсан байх;", Улсын Их Хурлын 2020 оны "Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл батлах тухай" 23 дугаар тогтоолын 2-т "Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан төсөл, арга хэмжээний санхүүжилтийг тухайн жилийн улсын төсөвт тусгаж байхыг ... ", Улсын Их Хурлын 2024 оны "Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай" 21 дүгээр тогтоолын 3-т "Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт дэвшүүлсэн зорилтыг дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө болон жил бүрийн улсын төсөвт тусган хэрэгжүүлэх;", УИХ-ын 2024 оны "Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай" 35 дугаар тогтоолын 1-т "Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөнд туссан улсын төсвийн эх үүсвэрээр санхүүжүүлэх шаардлагатай төсөл, арга хэмжээг Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлд тусгах;" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Урт болон дунд хугацааны бодлогын баримт бичгүүдэд тусгасан хөтөлбөр, арга хэмжээг улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөтэй уялдуулан төлөвлөх, шалгуур үзүүлэлт, хэмжих нэгж, үнэлэх аргачлалыг тодорхой болгох, гүйцэтгэлийг төсөвтэй уялдуулан тайлагнах зөвлөмж өгсөн.

Илрүүлэлт 4: Төсвийн төслийг боловсруулахдаа улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөтэй уялдуулан боловсруулаагүй, улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд туссан зарим төсөл, арга хэмжээний төсвийг батлуулаагүй, эх үүсвэр тодорхойгүй, төсөвт өртгийг зөрүүтэй тусгасан, хэрэгжүүлэх төсөл арга хэмжээ хасагдсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3-т "Төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн эрхлэх асуудлын төсвийн орлого, зарлагын зүй зохистой, үр ашигтай байдал, үр дүнгийн

гүйцэтгэлийг хангаж, өөрт хамаарах төсвийн гүйцэтгэлийн биелэлтийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засгийн газар, Улсын Их Хурлын өмнө бүрэн хариуцна.", 27 дугаар зүйлийн 27.1.8-д "Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд суурилсан байх"; УИХ-ын 2024 оны "Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөө батлах тухай" 35 дугаар тогтоолын 1-т "Монгол Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөнд туссан улсын төсвийн эх үүсвэрээр санхүүжүүлэх шаардлагатай төсөл, арга хэмжээг Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлд тусгах;" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн төслийг улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд үндэслэн боловсруулах зөвлөмж өгсөн.

Илрүүлэлт 5: Зам, тээврийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллага АТҮТ ТӨҮГ эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшнээр 1,240.0 сая төгрөгийн ашигтай ажиллахаар баталсан боловч 1,994.7 сая төгрөгийн, АЗЗАН ТӨХК 332.5 сая төгрөгийн ашигтай ажиллахаар баталсан боловч 1,534.8 сая төгрөгийн, МИАТ ТӨХК 13,622.9 сая төгрөгийн ашигтай ажиллахаар баталсан боловч 32,841.4 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах", 14.2.11-д "төсвийн зарцуулалтын үр ашгийг сайжруулах, үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, чиг үүргийн давхардал, эсхүл хийдлийг арилгах, бүтээмжийг дээшлүүлэх, төрөөс иргэдэд хүргэх үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилгоор өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсвийн бусад байгууллагад 3-5 жил тутамд нэг удаа чиг үүрэг, үр дүнгийн иж бүрэн шинжилгээ хийж, үр дүнг Засгийн газарт танилцуулах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн өмчийн оролцоотой компаниудын ашигт ажиллагааг дээшлүүлэх, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэлийг хангаж ажиллах зөвлөмж өгсөн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй, мөн бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны аудитаар төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлсэн 2 албан шаардлага, 9 зөвлөмж өгснийг үнэлэхэд албан шаардлага, зөвлөмж 79.5 хувийн хэрэгжилттэй байна.

Хүснэгт 13. Албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт /сая төгрөгөөр/

Д.д	Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
1.	Албан шаардлага	2	-	2	-	100.0
2.	Зөвлөмж	9	29,926.8	4	22,353.1	75.0
	Нийт дүн	11	29,926.8	6	22,353.1	79.5

1. Авто Импекс ТӨХК он удаан жил болсон урт хугацаат зээл, урт хугацаат хөрөнгө оруулалт, авлага, өр төлбөрийг холбогдох байгууллагын саналыг авч, хууль тогтоомжийн дагуу шийдвэрлүүлэхээр өгсөн зөвлөмж тус байгууллага Эрчист Монгол ХХК руу шилжсэнээс хэрэгжээгүй тул дараагийн аудитаар авч үзэх;
2. Төслийн хүрээнд бэлтгэсэн хөрөнгийг бүртгэж, зээлийн эргэн төлөлтийн асуудлыг холбогдох хууль, тогтоомжийн дагуу шийдвэрлэх, хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр нийлүүлсэн хөрөнгө болон өр төлбөрийн асуудлыг холбогдох байгууллагын саналыг авч,

хууль, тогтоомжийн дагуу шийдвэрлэх, Чингис хаан банканд байршиж байгаа мөнгөн хөрөнгийг буцаан татах асуудлаар тодорхой арга хэмжээ авч ажиллах талаар өгсөн зөвлөмжийг Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар үзэх;

3. АЗЗАН ТӨХК-ийн орон нутгийн зарим салбарууд хувь хүн, хуулийн этгээдтэй зээлийн гэрээ байгуулж, хүүтэй зээл авч үйл ажиллагаандаа зарцуулсан зөрчлийг давтан гарахгүй байх, төсөв санхүү, орлогын эх үүсвэрийг зохистой удирдаж, үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах талаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй тул албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Аудитыг гүйцэтгэх цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан Төмөр замын газрын ажилчдын орон сууцны барилгын ажил, гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжиж байгаа төсөл, арга хэмжээний үр дүнд бий болсон хөрөнгийг гүйцээн мөшгиж амжаагүй тул горим, сорил хэрэгжүүлэх;

Авто Импекс ТӨХК-ийн асуудал болон төслийн хүрээнд бэлтгэсэн хөрөнгийг бүртгэж, зээлийн эргэн төлөлтийн асуудлыг холбогдох хууль, тогтоомжийн дагуу шийдвэрлэх, хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр нийлүүлсэн хөрөнгө болон өр төлбөр, Чингис хаан банканд байршиж байгаа мөнгөн хөрөнгийг буцаан татах асуудлыг нарийвчлан үзэх;

Мөн МТЗ ТӨХК нэгдсэн санхүүгийн тайлангаа бэлтгэж, аудитад бүрэн хамруулсан эсэх, Монголиан порт групп ХХК, Шинэ төмөр зам ХХК-ийн үйл ажиллагаанд анхаарал хандуулах шаардлагатай байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Зам, тээврийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой нийт 713,466.0 сая төгрөгийн 47 алдаа илэрснийг аудитын явцад залруулсан.

Аудитаар нийт 358,893.2 сая төгрөгийн 220 зөрчил илэрснээс 692.2 сая төгрөгийн зөрчилд 28 төлбөрийн акт тогтоож, 323,577.0 сая төгрөгийн зөрчилд 88 албан шаардлага хүргүүлж, зөрчлийг давтан гаргахгүй байх 29,147.7 сая төгрөгийн 101 зөвлөмж өгч, сахилгын хариуцлага тооцуулах 5,476.3 сая төгрөгийн 3 албан шаардлага хүргүүлсэн.

Зам, тээврийн сайдын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар илэрсэн 358,893.2 сая төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшин 11,685.2 сая төгрөгөөс давсан тул “Хязгаарлалттай” дүгнэлт өглөө.

5.1 Харьяа байгууллагууд

Зам, тээврийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд 17 байгууллага нэгтгэснээс 11 байгууллагад дүгнэлт гаргаж, 6 байгууллага аудитын түүвэрт хамрагдсан.

Санал дүгнэлт гаргасан 11 байгууллагаас 1 байгууллагын санхүүгийн тайланд “Өөрчлөлтгүй” дүгнэлт, 10 байгууллагын санхүүгийн тайланд “Хязгаарлалттай” дүгнэлт өгсөн.

Харьяа байгууллагуудад хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар нийт 358,711.0 сая төгрөгийн 215 зөрчил илэрснээс 692.2 сая төгрөгийн 28 төлбөрийн акт тогтоож, 323,394.8 сая төгрөгийн 86 албан шаардлага хүргүүлж, зөрчлийг давтан гаргахгүй байх 29,147.7 сая төгрөгийн 98 зөвлөмж, сахилгын хариуцлага тооцуулах 5,476.3 сая төгрөгийн 3 албан шаардлага хүргүүлсэн.

Санхүүгийн тайлангийн аудитаар хийсэн нийцлийн аудитаар 267,973.3 сая төгрөгийн 64 зөрчил илэрснээс 247,596.7 сая төгрөгийн зөрчилд 28 албан шаардлага хүргүүлж, 20,038.0 сая төгрөгийн зөрчилд 35 зөвлөмж өгч, сахилгын хариуцлага тооцуулах 338.6 сая төгрөгийн 1 албан шаардлага өгсөн.

5.2 Төсвийн ерөнхийлөн захирагч

Аудитаар нийт 182.2 сая төгрөгийн 5 зөрчил илэрснээс 182.2 сая төгрөгийн 2³ албан шаардлага, алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өгсөн.

5.2.1 Албан шаардлага

Зам, тээврийн сайдын эрхлэх асуудлын хүрээний зарим байгууллагууд бүтцийн өөрчлөлтөөр ажлаас чөлөөлөгдсөн албан хаагчид ажлаас халагдсаны тэтгэмж олгож, нарийн мэргэжил шаардахгүй ажил болон тухайн салбарын бусад байгууллагад сонгон шалгаруулалтгүйгээр томилсон байна. Тухайлбал,

1. ИНЕГ бүтцийн өөрчлөлтөөр орон тоо хасагдсан дотоод аудитын албаны менежер 31.3 сая төгрөгийн тэтгэмж олгож, Иргэний нисэхийн бодлогын хэрэгжилтийн газрын менежер, Захиргаа удирдлага, хууль эрх зүйн газрын даргаар тус тус томилсон;
2. ИНЕГ санхүүгийн аудитораар ажиллаж байсан нэр бүхий ажилтныг бүтцийн өөрчлөлтөөр ажлаас чөлөөлөхдөө өөр ажлын байр санал болгосон бөгөөд тухайн ажилтан ажлаас чөлөөлөгдөж, АХОЗШША-нд сонгон шалгаруулалтгүйгээр нягтлан

³ Өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүйгээс албан шаардлага өгсөн дүнг оруулсан.
САГ-2026/7/НА-СТА-ТЕЗ

бодогчийн албан тушаалд томилогдож, ажиллаж байх хугацаандаа шүүхээр маргаж 24 сарын дундаж цалин хөлстэй тэнцэх хэмжээний тэтгэмж 145.4 сая төгрөг, цалин, урамшуулал 4.4 сая төгрөг, улсын тэмдэгтийн хураамж 0.9 сая төгрөг, шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зардал 0.2 сая төгрөг, нийт 150.9 сая төгрөгийг Нийслэлийн Иргэний хэргийн Давж заалдах шатны шүүхийн 2025 оны 210/МА2025/01751 дугаар магадлалыг үндэслэн олгосон;

3. Нэр бүхий байгууллагад ерөнхий нягтлан бодогчоор ажиллаж байсан ажилтныг бүтцийн өөрчлөлтөөр чөлөөлж, тухайн байгууллагад санхүүгийн аудитораар томилсон нь ашиг сонирхлын зөрчил үүсэх, дотоод хяналт үр нөлөөгүй байх эрсдэлтэй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.11, 14.2.12 дахь хэсэг, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3, 21 дүгээр зүйлийн 21.1, 21.1.1 дэх хэсэг, Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1, 103.2 дахь хэсэгт заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Ажил олгогчийн санаачилгаар ажлаас чөлөөлөгдөж, тэтгэмж олгосон ажилтныг буцааж ажилд томилдог, сонгон шалгаруулалтгүйгээр ажилтан томилсон, ажилтнуудыг өөр албан тушаалд томилохдоо өөрийн ажиллаж байх хугацааны ажлыг хянах, шалгах, шийдвэр гаргах зэрэг ашиг сонирхлын зөрчил үүсэж болзошгүй албан тушаалд томилдог зөрчлийг таслан зогсоох, захиргааны байгууллагын дотоод аудитын нэгж байгууллагад учирсан хохирлыг гэм буруутай этгээдээр нөхөн төлүүлэх албан шаардлага хүргүүлсэн.

5.2.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Цалинтай холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт:

1. Зам, тээврийн сайдын эрхлэх асуудлын хүрээний зарим байгууллагууд цалингийн зардлыг хэтрүүлсэн, ажлын байрны жагсаалт, орон тоогоор батлаагүй албан тушаалын орон тоог бий болгож, хавсран ажилласан цалингийн нэмэгдэл олгосон, цалингийн нэмэгдэл, үр дүнгийн урамшуулал, илүү цагийн хөлсийг холбогдох хууль тогтоомжийн дагуу олгоогүй, буруу тооцоолж, илүү олгосон, томилолтоор ажилласан хугацаанд хоол унааны мөнгийг давхардуулан олгосон зэрэг зөрчлийг нийтлэг гаргасан байна. Тухайлбал,

- Цалингийн батлагдсан төсвийг МИАТ ТӨХК 2,893.0 сая төгрөгөөр, ИНҮТ ТӨХХК 963.2 сая төгрөгөөр тус тус хэтрүүлсэн;
- ИНЕГ улирлын мөнгөн урамшууллын дээд хэмжээг хэтрүүлэн сар бүр 40 хувиар тооцож урамшуулалд нийт 1,340.5 сая төгрөгийг олгосон;
- ИНЕГ, ИНҮТ ТӨХХК албан томилолтоор ажилласан албан хаагчдын цалин хөлсийг тооцохдоо нийт 70.0 сая төгрөгийг илүү олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5.1.3-д "санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх;", 5.1.5-д "хариуцлагатай байх.", 14 дүгээр зүйлийн 14.2.3-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах;", 14.2.10-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх.", 14.2.12-т "эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төсөвт байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, чиг үүргийн давхардлыг арилгах,

ажлын ачааллыг нягтруулах, бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор чиг үүрэг, зохион байгуулалтын бүтцийг батлагдсан орон тооны хязгаар, төсөвт багтаан шинэчлэн тогтоох." гэж заасныг хэрэгжүүлж, ажиллаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын цалинтай холбогдон гарч байгаа зөрчлийн шалтгаан нөхцөлийг тогтоож, зөрчлийг давтан гаргахгүй байх, дотоод хяналтыг үр нөлөөтэй хэрэгжүүлэх.

2. Зорилтот түвшинтэй холбоотой асуудал

2.1 Илрүүлэлт:

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн 1 дүгээр хавсралтаар Зам, тээврийн сайдын 4 хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх 10 арга хэмжээг баталсан байна. Үүнээс 5 арга хэмжээ тайлант оны зорилтот түвшнийг хангаагүй байна. Үүнд:

- Арцсуурь боомт – Шивээхүрэн боомт чиглэлийн баруун босоо 1255 км төмөр замын төслийн ажлын гүйцэтгэл 10 хувь;
- Ашиглалтад оруулах олон улс, улсын болон орон нутгийн чанартай авто замын төсөл 330.3 км буюу 26.5 хувь;
- Байнгын ашиглалтад оруулах гүүрний нийт хүчин чадал 217 метр буюу 79.1 хувь;
- Гашуунсухайт – Ганцмод чиглэлийн хил дамнасан төмөр замын төслийн ажлын гүйцэтгэл 80 хувийн биелэлттэй;
- Эрдэм шинжилгээ, туршилт, судалгаа, Лабораторийн туршилт, шинжилгээний дүгнэлт төсөл, арга хэмжээнүүд хэрэгжээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3-д "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд төсвийг үр ашигтай удирдах, гүйцэтгэлийг хангах;" 14.2.8-д "хөрөнгө оруулалтын арга хэмжээний хэрэгжилтийг төсвийн гүйцэтгэлийн явцад хянаж, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад улирал бүр тайлагнах;" 14.3-т "Төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн эрхлэх асуудлын төсвийн орлого, зарлагын зүй зохистой, үр ашигтай байдал, үр дүнгийн гүйцэтгэлийг хангаж, өөрт хамаарах төсвийн гүйцэтгэлийн биелэлтийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засгийн газар, Улсын Их Хурлын өмнө бүрэн хариуцна." гэж заасныг тус тус хэрэгжүүлж, ажиллаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулиар баталсан хөтөлбөр, арга хэмжээний зорилтот түвшний үзүүлэлтийг хангаж ажиллах.

3. Дотоод хяналттай холбоотой асуудал

3.1 Илрүүлэлт:

Тайлант онд Санхүүгийн тайлангийн аудитаар харьяа байгууллагуудад залруулагдаагүй нийт 358,710.9 сая төгрөгийн 220 зөрчил илэрсэн нь өмнөх оноос 19,157.8 сая төгрөгөөр буурсан байна. Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар санхүүгийн хяналт шалгалтаар төлөвлөгөөт 11 байгууллагыг шалгалтад хамруулахаас 8 байгууллагад санхүүгийн хяналт шалгалт хийж, 1 байгууллагыг хамруулаагүй, 2 байгууллагын хяналт, шалгалтын ажил дуусаагүй, холбогдох журам шинэчлэгдсэнээс бодлогын баримт бичигт үнэлгээ хийгээгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.5-т "хариуцлагатай байх.", 6 дугаар зүйлийн 6.6.1-т "төсвийн захирагч нь түүнийг томилсон байгууллага, албан тушаалтны өмнө, эсхүл дээд шатныхаа төсвийн захирагчийн өмнө төсвийн талаар хариуцлага хүлээдэг байх;"

14.2.10-т "өөрийн эрхлэх асуудлын хүрээнд дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх.", Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан "Үнэлгээ хийх журам"-ын 4.3-т "Байгууллага дараах чиг үүрэгтэй байна:", 4.3.1-т "жил бүр нэг ба түүнээс дээш бодлогын баримт бичигт үнэлгээ хийх;" гэж заасныг тус тус хэрэгжүүлж, ажиллаагүй байна.

Өгсөн зөвлөмж: Тайлант онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн арга хэмжээг, хугацаанд нь чанартай хийж, гүйцэтгэх, дотоод аудитыг үр дүнтэй хэрэгжүүлж, зөрчлийг бууруулах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Үндэсний аудитын газарт 2026 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**6.1 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын алдааны нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

№	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс			
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй	
								Тоо	Дүн	Тоо	Дүн
	Төсвийн шууд захирагч										
1	ЗТЯ	1	657,368.3	-	-	1	657,368.3	1	657,368.3		
2	ИНЕГ	3	301,271.1	1	198,000.0	2	103,271.1	3	301,271.1	-	-
3	Төмөр замын газар	4	176,640.1	-	-	4	176,640.1	4	176,640.1		
4	ЗТЯ-ны хөрөнгө оруулалт	1	40,524,790.6	-	-	1	40,524,790.6	1	40,524,790.6		
5	АЗННС	1	3,277,723.1	-	-	1	3,277,723.1	1	3,277,723.1		
	Нийт дүн	10	44,937,793.2	1	198,000.0	9	44,739,793.2	10	44,937,793.2	-	-
	Засгийн газрын тусгай сан										
1	УАЗС	4	4,335,526.6	1	3,633,586.4	3	701,940.2	4	4,335,526.6		
	Нийт дүн	4	4,335,526.6	1	3,633,586.4	3	701,940.2	4	4,335,526.6		
	ТӨҮГ										
1	АТҮТ ТӨҮГ	1	11,152,967.3	-	-	1	11,152,967.3	1	11,152,967.3		
2	АЗЗАН – аппарат	6	296,515.4	1	171,094.0	5	125,421.4	6	296,515.4		
3	АЗЗАН – Булган салбар	1	33,000.0	-	-	1	33,000.0	1	33,000.0		
4	АЗЗАН – Завхан салбар	4	553,966.2	-	-	4	553,966.2	4	553,966.2		
5	АЗЗАН – Төв салбар	2	19,460.0	-	-	2	19,460.0	2	19,460.0		
6	ЗТХТ ТӨҮГ	5	1,529,789.1	1	-	4	1,529,789.1	5	1,529,789.1		
7	ИНҮТ ТӨХХК	1	551,385,825.2	1	551,385,825.2	-	-	1	551,385,825.2		
8	ИНҮТ – Булган нисэх буудал	1	407.6	-	-	1	407.6	1	407.6		
9	ИНҮТ – Гурвансайхан нисэх буудал	3	4,579.4	-	-	3	4,579.4	3	4,579.4		
10	МУДЗ	3	86,373.7	-	-	3	86,373.7	3	86,373.7	-	-
11	МИАТ ТӨХК	6	99,129,832.9	-	-	6	99,129,832.9	6	99,129,832.9	-	-
	Нийт дүн	33	664,192,716.8	3	551,556,919.2	30	112,635,797.6	33	664,192,716.8		
	НИЙТ ДҮН	47	713,466,036.6	5	555,388,505.6	42	158,077,531.0	47	713,466,036.6		

6.2 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Байгууллагын нэр	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцох	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
	Төсвийн шууд захирагч										
1	ЗТЯ	8	1,226,415.5	1	4,423.0	3	1,145,636.5	4	76,356.0	-	-
2	Төмөр замын газар	2	5,558.5	-	-	1	5,558.5	1	-	-	-
3	ИНЕГ	19	2,270,396.9	3	76,431.9	10	1,589,825.1	5	604,139.9	1	-
4	ЗТЯ-ны хөрөнгө оруулалт	4	116,366,159.7	1	434,271.9	3	115,931,887.8	-	-	-	-
5	АЗННС	5	391,254.0	-	-	4	381,653.1	1	9,600.9	-	-
6	АХОЗШША	7	116,036.0	1	28,457.5	2	33,670.6	4	53,907.9	-	-
	Нийт дүн	45	120,375,820.6	6	543,584.3	23	119,088,231.6	15	744,004.7	1	-
	Засгийн газрын тусгай сан										
1	УАЗС	6	7,382,869.2	-	-	2	976,117.7	4	6,406,751.5	-	-
2	ТАЦ	7	134,848.8	2	4,220.0	1	104,490.0	3	26,138.8	1	-
	Нийт дүн	13	7,517,718.0	2	4,220.0	3	1,080,607.7	7	6,432,890.3	1	-
	ТӨҮГ										
1	АТҮТ аппарат	3	3,386,497.0	-	-	3	3,386,497.0	-	-	-	-
2	АТҮТ Архангай салбар	1	-	-	-	1	-	-	-	-	-
3	АТҮТ Дорноговь салбар	1	69,547.8	-	-	-	-	1	69,547.8	-	-
4	АТҮТ Дорнод салбар	2	14,745.7	-	-	-	-	2	14,745.7	-	-
5	АТҮТ Завхан салбар	2	3,082.0	-	-	-	-	2	3,082.0	-	-
6	АТҮТ Орхон салбар	3	60.0	-	-	-	-	3	60.0	-	-
7	АТҮТ Сэлэнгэ салбар	2	-	-	-	-	-	2	-	-	-
8	АТҮТ Төв салбар	1	-	-	-	-	-	1	-	-	-
9	АТҮТ Ховд салбар	2	8,356.3	-	-	-	-	2	8,356.3	-	-
10	АТҮТ ТӨҮГ-ийн дүн	17	3,482,288.8	-	-	4	3,386,497.0	13	95,791.8	-	-
11	АЗЗАН аппарат	8	25,943,312.9	-	-	5	25,197,228.6	3	746,084.3	-	-
12	АЗЗАН Багануур салбар	5	58,000.2	-	-	1	55,546.2	4	2,454.0	-	-
13	АЗЗАН Баянчандмань салбар	4	99,184.3	-	-	1	49,428.3	3	49,756.0	-	-
14	АЗЗАН Булган салбар	1	1,335.3	1	1,335.3	-	-	-	-	-	-
15	АЗЗАН Говь-Алтай салбар	3	600.0	1	600.0	-	-	2	-	-	-
16	АЗЗАН Дархан салбар	5	159,859.9	1	252.0	-	-	4	159,607.9	-	-
17	АЗЗАН Дорноговь салбар	2	-	-	-	1	-	1	-	-	-
18	АЗЗАН Завхан салбар	1	24,081.1	-	-	-	-	1	24,081.1	-	-
19	АЗЗАН Налайх салбар	7	431,082.3	-	-	3	389,187.1	4	41,895.2	-	-
20	АЗЗАН Орхон салбар	8	1,347,356.9	3	5,588.3	3	1,063,717.4	2	278,051.2	-	-
21	АЗЗАН Сэлэнгэ салбар	4	72,484.3	2	5,587.4	2	66,896.9	-	-	-	-
22	АЗЗАН Төв салбар	5	4,372,877.0	1	2,477.5	1	169,427.6	3	4,200,971.9	-	-
23	АЗЗАН Увс салбар	3	43,726.4	-	-	1	5,459.8	2	38,266.6	-	-
24	АЗЗАН Ховд салбар	1	754,600.0	-	-	-	-	1	754,600.0	-	-
25	АЗЗАН Хөвсгөл салбар	1	2,200.0	-	-	-	-	1	2,200.0	-	-

Зам, тээврийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитын тайлан

26	АЗЗАН Хэнтий салбар	1	7,334.6	1	7,334.6	-	-	-	-	-	-
27	АЗЗАН Эрдэнэсант салбар	7	99,552.6	3	10,415.0	3	86,840.9	1	2,296.7	-	-
28	АЗЗАН ТӨХК-ийн дүн	66	33,417,587.8	13	33,590.1	21	27,083,732.8	32	6,300,264.9	-	-
29	ЗТХТ ТӨҮГ	6	7,982,498.5	-	-	3	2,506,211.4	2	-	1	5,476,287.1
30	ИНҮТ аппарат	20	22,858,878.5	2	106,334.7	8	8,100,376.3	10	14,652,167.5	-	-
31	ИНҮТ Булган нисэх буудал	5	21,904.8	2	930.0	1	18,950.0	2	2,024.8	-	-
32	ИНҮТ Өндөрхаан нисэх буудал	2	2,979.6	2	2,979.6	-	-	-	-	-	-
33	ИНҮТ Тосон цэнгэл нисэх буудал	3	12,353.5	1	600.0	-	-	2	11,753.5	-	-
34	ИНҮТ ТӨХХК-ийн дүн	30	22,896,116.4	7	110,844.3	9	8,119,326.3	14	14,665,945.8	-	-
35	МУДЗ	5	1,402,864.3	-	-	2	951,966.4	3	450,897.9	-	-
36	МТЗ ТӨХК	10	36,326,841.9	-	-	8	36,276,602.4	2	50,239.5	-	-
37	МИАТ ТӨХК	16	125,249,452.0	-	-	11	124,884,388.5	5	365,063.5	-	-
38	ХХНОБ ТӨХХК	4	28,983.4	-	-	1	8,166.7	3	20,816.7	-	-
39	Шивээ хүрэн төмөр зам ХХК	3	30,764.3	-	-	1	9,000.0	2	21,764.3	-	-
	Нийт дүн	157	230,817,397.4	20	144,434.4	60	203,225,891.5	76	21,970,784.4	1	5,476,287.1
	Төсвийн ерөнхийлөн захирагч										
1	Зам, тээврийн сайд	5	182,223.5	-	-	2	182,223.5	3	-	-	-
	Нийт дүн	5	182,223.5	-	-	2	182,223.5	3	-	-	-
	НИЙТ ДҮН	220	358,893,159.5	28	692,238.7	88	323,576,954.3	101	29,147,679.4	3	5,476,287.1

6.3 Санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

№	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцох	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
	Төсвийн шууд захирагч										
1	ЗТЯ	1	13,166,573.8	-	-	1	13,166,573.8	-	-	-	-
2	ИНЕГ	9	873,313.0	-	-	7	873,313.0	2	-	-	-
3	ТЗГ	1	496,691.4	-	-	1	496,691.4	-	-	-	-
4	ЗТЯ-ны хөрөнгө оруулалт	3	173,482,377.4	-	-	2	173,482,377.4	1	-	-	-
5	АЗННС	5	2,648,815.1	-	-	2	-	3	2,648,815.1	-	-
6	АХОЗШША	5	63,490.2	-	-	1	40,384.8	4	23,105.4	-	-
	Нийт дүн	24	190,731,260.9	-	-	14	188,059,340.4	10	2,671,920.5	-	-
	Засгийн газрын тусгай сан										
1	УАЗС	4	37,568,084.5	-	-	2	22,775,328.7	2	14,792,755.8	-	-
2	ТАЦ	4	2,440,063.3	-	-	2	2,440,063.3	2	-	-	-
	Нийт дүн	8	40,008,147.8	-	-	4	25,215,392.0	4	14,792,755.8	-	-
	ТӨҮГ										
1	АТҮТ аппарат	2	-	-	-	1	-	1	-	-	-
2	АТҮТ Дорнод салбар	1	-	-	-	-	-	1	-	-	-
3	АТҮТ ТӨҮГ-ийн дүн	3	-	-	-	1	-	2	-	-	-
4	АЗЗАН аппарат	2	3,505,934.1	-	-	1	2,147,188.5	1	1,358,745.6	-	-
5	АЗЗАН Багануур салбар	1	-	-	-	-	-	1	-	-	-
6	АЗЗАН Булган салбар	1	125,791.9	-	-	-	-	1	125,791.9	-	-
7	АЗЗАН Баянчандмань салбар	1	-	-	-	-	-	1	-	-	-
8	АЗЗАН Дархан салбар	1	13,555.1	-	-	1	13,555.1	-	-	-	-
9	АЗЗАН Дорноговь салбар	1	-	-	-	-	-	1	-	-	-
10	АЗЗАН Налайх салбар	1	106,500.9	-	-	-	-	1	106,500.9	-	-
11	АЗЗАН Орхон салбар	1	-	-	-	1	-	-	-	-	-
12	АЗЗАН ТӨХК-ийн дүн	9	3,751,782.0	-	-	3	2,160,743.6	6	1,591,038.4	-	-
13	ЗТХТ ТӨҮГ	2	-	-	-	-	-	2	-	-	-
14	ИНҮТ аппарат	8	121,341.7	-	-	2	-	6	121,341.7	-	-
15	ИНҮТ Булган нисэх буудал	1	766,124.7	-	-	-	-	1	766,124.7	-	-
16	ИНҮТ Чойбалсан нисэх буудал	1	-	-	-	-	-	1	-	-	-
17	ИНҮТ Арвайхээр нисэх буудал	1	94,800.0	-	-	-	-	1	94,800.0	-	-
18	ИНҮТ ТӨХХК-ийн дүн	11	982,266.4	-	-	2	-	9	982,266.4	-	-
19	МУДЗ	1	338,584.2	-	-	-	-	-	-	1	338,584.2
20	МТЗ ТӨХК	2	-	-	-	1	-	1	-	-	-
21	МИАТ ТӨХК	3	32,133,360.7	-	-	2	32,133,360.7	1	-	-	-
22	ХХНОБ ТӨХХК	1	27,856.6	-	-	1	27,856.6	-	-	-	-
	Нийт дүн	32	37,233,849.9	-	-	10	34,321,960.9	21	2,573,304.8	1	338,584.2
	Төсвийн ерөнхийлөн захирагч										
1	Зам, тээврийн сайд	7	-	-	-	1	-	6	-	-	-
	Нийт дүн	7	-	-	-	1	-	6	-	-	-
	НИЙТ ДҮН	71	267,973,258.6	-	-	29	247,596,693.3	41	20,037,981.1	1	338,584.2



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 04 сарын 24 өдөр

Дугаар 1411/А0111371

Улаанбаатар хот

САГ-2026/7/НА-СТА-ТЕЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Зам, тээврийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Зам, тээврийн сайдын эрхлэх асуудлын хүрээний зарим байгууллагууд бүтцийн өөрчлөлтөөр ажлаас чөлөөлөгдсөн албан хаагчид ажлаас халагдсаны тэтгэмж олгож, нарийн мэргэжил шаардахгүй ажил болон тухайн салбарын бусад байгууллагад сонгон шалгаруулалтгүйгээр томилсон байна. Тухайлбал,

1. Иргэний нисэхийн ерөнхий газар бүтцийн өөрчлөлтөөр орон тоо хасагдсан дотоод аудитын албаны менежерт 31,327,945.73 /Гучин нэгэн сая гурван зуун хорин долоог мянга есөн зуун дөчин таван таван төгрөг далан гурван мөнгө/ төгрөгийн тэтгэмж олгож, Иргэний нисэхийн бодлогын хэрэгжилтийн газрын менежер, Захиргаа удирдлага, хууль эрх зүйн газрын даргаар тус тус томилсон;
2. Иргэний нисэхийн ерөнхий газар санхүүгийн аудитораар ажиллаж байсан нэр бүхий ажилтныг бүтцийн өөрчлөлтөөр ажлаас чөлөөлөхдөө өөр ажлын байр санал болгосон бөгөөд тухайн ажилтан ажлаас чөлөөлөгдөж, Агаарын хөлгийн осол зөрчлийг шинжлэн шалгах албанд сонгон шалгаруулалтгүйгээр нягтлан бодогчийн албан тушаалд томилогдож, ажиллаж байх хугацаандаа шүүхээр маргаж 24 сарын дундаж цалин хөлстэй тэнцэх хэмжээний тэтгэмж 145,373,671.00 /Нэг зуун дөчин таван сая гурван зуун далан гурван мянга зургаан зуун далан нэгэн/ төгрөг, цалин, урамшуулал 4,436,653.00 /Дөрвөн сая дөрвөн зуун гучин зургаан мянга зургаан зуун тавин гурван/ төгрөг, улсын тэмдэглэлийн хураамж 884,819.00 /Найман зуун наян дөрвөн мянга найман зуун арван есөн/ төгрөг, шийдвэр гүйцэтгэх ажиллагааны зардал 200,400.00 /Хоёр зуун мянга дөрвөн зуун/ төгрөг, нийт 150,895,543.00 /Нэг зуун тавин сая найман зуун ерэн таван мянга таван зуун дөчин гурван/ төгрөгийг Нийслэлийн Иргэний хэргийн Давж заалдах шатны шүүхийн 2025 оны 210/МА2025/01751 дугаар магадлал, Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын 2026 оны 04-196/4338 дугаар мэдэгдлээр олгосон;
3. Нэр бүхий байгууллагад ерөнхий нягтлан бодогчоор ажиллаж байсан ажилтныг бүтцийн өөрчлөлтөөр чөлөөлж, тухайн байгууллагад санхүүгийн аудитораар томилсон нь ашиг сонирхлын зөрчил үүсэх, дотоод хяналт үр нөлөөгүй байх эрсдэлтэй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.11-д "төсвийн зарцуулалтын үр ашгийг сайжруулах, үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, чиг үүргийн давхардал, эсхүл хийдлийг арилгах, бүтээмжийг дээшлүүлэх, төрөөс иргэдэд хүргэх үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах зорилгоор өөрийн эрхлэх асуудлын хүрээний агентлаг, төсвийн бусад байгууллагад 3-5 жил тутамд нэг удаа чиг үүрэг, үр дүнгийн иж бүрэн шинжилгээ хийж, үр дүнг Засгийн газарт танилцуулах;" , 14.2.12-т "эрхлэх асуудлын хүрээнд хамаарах төсөвт байгууллагын үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх, чиг үүргийн давхардлыг арилгах, ажлын ачааллыг нягтруулах, бүтээмжийг дээшлүүлэх зорилгоор чиг үүрэг, зохион байгуулалтын бүтцийг батлагдсан орон тооны хязгаар, төсөвт багтаан шинэчлэн тогтоох.", Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3-т "Албан тушаалтан тухайн албан тушаалд сонгогдох, томилогдохоосоо өмнө аж ахуйн нэгжийн удирдах, гүйцэтгэх, хяналтын байгууллагын гишүүн байсан бол нийтийн албанд орсон, эсхүл тухайн аж ахуйн нэгжтэй иргэний эрх зүйн аливаа харилцааг дуусгавар болгосноос хойш хоёр жилийн хугацаанд тухайн аж ахуйн нэгжийн үйл ажиллагаатай холбогдох захиргааны шийдвэр гаргахыг хориглоно.", 21 дүгээр зүйлийн 21.1-д "Албан тушаалтан нь албан үүргээс чөлөөлөгдсөнөөс хойш хоёр жилийн хугацаанд ашиг сонирхлын зөрчил үүсч болох дараах үйл ажиллагаа явуулахыг хориглоно:", 21.1.1-д "урьд гүйцэтгэж байсан албан үүрэгтэй нь холбоотой байсан аж ахуйн нэгж, байгууллагад ажиллах;", Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйл "Захиргааны байгууллага хохирлоо барагдуулах", 103.1-д "Иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага Иргэний хуулийн 498.5-д заасны дагуу гэм буруутай этгээдээр буцааж төлүүлнэ.", 103.2-т "Энэ хуулийн 103.1-д заасан гэм буруутай этгээдээр хохирлыг төлүүлэх үүргийг тухайн захиргааны байгууллагын дээд шатны байгууллагын дотоод аудитын нэгж хариуцна." гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.10-т "аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол", 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Ажил олгогчийн санаачилгаар ажлаас чөлөөлөгдөж, тэтгэмж олгосон ажилтныг буцааж ажилд томилдог, сонгон шалгаруулалтгүйгээр ажилтан томилсон, ажилтнуудыг өөр албан тушаалд томилохдоо өөрийн ажиллаж байх хугацааны ажлыг хянах, шалгах, шийдвэр гаргах зэрэг ашиг сонирхлын зөрчил үүсэж болзошгүй албан тушаалд томилдог зөрчлийг таслан зогсоох;
2. Дотоод аудитын нэгж байгууллагад учирсан хохирлыг гэм буруутай этгээдээр нөхөн төлүүлээгүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

3. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Зам, тээврийн сайд /Б.Дэлгэрсайхан/, тус яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /М.Баярмагнай/, Санхүү хөрөнгө оруулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Т.Сумъяа/ нарт даалгав.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:



С.МАГНАЙСҮРЭН



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 04 сарын 24 өдөр

Дугаар 1412/АО111371

Улаанбаатар хот

САГ - 2026/7/КА - СТА - ТЕЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Зам, тээврийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Зам, тээврийн сайдын 2025 оны А/102 дугаар тушаалаар худалдан авах ажиллагааны төлөвлөгөө баталсан байна. Худалдан авах ажиллагааг зохион байгуулах эрхийг мэргэжлийн байгууллагад хугацаа хоцроож шилжүүлсэн, зарим төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг хуулийн хугацаанд зохион байгуулаагүй байна. Үүнд:

1. Арабын эдийн засгийн хөгжлийн Кувейтийн сангийн буцалтгүй тусламжаар санхүүжүүлэх 888,000,000.00 /Найман зуун наян найман сая/ төгрөгийн төсөвт өртөгтэй 1 төсөл, арга хэмжээг 3 сараар, жолоочийн даатгалын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх 4,646,097,630.00 /Дөрвөн тэрбум зургаан зуун дөчин зургаан сая ерэн долоон мянга зургаан зуун гуч/ төгрөгийн төсөвт өртөгтэй 4 төсөл, арга хэмжээний жагсаалтыг 2 сараар хугацаа хоцроож, шилжүүлсэн,
2. Улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн нийт 114,438,679,944.00 /Нэг зуун арван дөрвөн тэрбум дөрвөн зуун гучин найман сая зургаан зуун далан есөн мянга есөн зуун дөчин дөрвөн/ төгрөгийн төсөвт өртөгтэй 12 төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг хуулийн хугацаанд зохион байгуулаагүй байна. Үүнд: Төрийн худалдан авах ажиллагааны газарт хэрэгжүүлэх 69,966,859,414.00 /Жаран есөн тэрбум есөн зуун жаран зургаан сая найман зуун тавин есөн мянга дөрвөн зуун арван дөрвөн/ төгрөгийн 4 төсөл арга хэмжээ, Зам, тээврийн яамны болон харьяа газарт хэрэгжүүлэх 44,471,820,530.00 /Дөчин дөрвөн тэрбум дөрвөн зуун далан нэгэн сая найман зуун хорин мянга таван зуун гуч/ төгрөгийн төсөвт өртөгтэй 8 төсөл, арга хэмжээ байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т "Төсвийн ерөнхийлөн захирагч нь төсөв хуваарилах, зарцуулахтай холбогдсон бүрэн эрхээ төсвийн төвлөрүүлэн захирагч, эсхүл харьяалах төсвийн шууд захирагчид шилжүүлж болох бөгөөд ийнхүү шилжүүлсэн нь түүнийг хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй", Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.7-д "Төсвийн ерөнхийлөн захирагч тухайн төсвийн жилд хэрэгжүүлэх энэ хуулийн 45.1, 45.2, 45.3, 45.4-т зааснаас бусад төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтыг зохион байгуулах эрхийг харьяалах доод шатны төсвийн захирагчид, эсхүл худалдан авах ажиллагааны мэргэжлийн байгууллагад шилжүүлэхээр шийдвэрлэсэн бол ажлын 10 өдрийн дотор шилжүүлнэ", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1-д "батлагдсан төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг жил бүрийн 05 дугаар сарын 31-ний өдрийн дотор бүрэн дуусгах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

Z: Alban.Shaardlaga.2026/04/24.SAG-42.Docx

1526182279

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох” журмын 4.2.1.11-д “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулах эрхийг мэргэжлийн байгууллагад хуулиар тогтоосон хугацаанд шилжүүлээгүй, худалдан авах ажиллагааг хуулийн хугацаанд хэрэгжүүлдэггүй зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Зам, тээврийн сайд /Б.Дэлгэрсайхан/, тус яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /М.Баярмагнай/, Санхүү хөрөнгө оруулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Т.Сумъяа/ нарт даалгав.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 04 сарын 24 өдөр

Дугаар 1413/АО111371

Улаанбаатар хот

САГ-2026/7/ИА - СТА-ТЭЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.5-д заасны дагуу Зам, тээврийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өмнөх оны аудитаар "Авто замын засвар арчлалтын нэгтгэл" ТӨХК-ийн орон нутгийн зарим салбарууд хувь хүн, хуулийн этгээдтэй зээлийн гэрээ байгуулж, үйл ажиллагаандаа зарцуулсан зөрчил илэрсэн. Байгууллага хүүтэй зээл авахгүй, төсөв санхүү, орлогын эх үүсвэрийг зохистой удирдаж, үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөх талаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ.", Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", 21.4-т "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журмыг Монгол Улсын Ерөнхий аудитор батална.", Монгол Улсын ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаал "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4-т "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох үндэслэл", 4.2.1.10-т "аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.


Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1.10-т "аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй бол", 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсөв санхүү, орлогын эх үүсвэрийг зохистой удирдаж, иргэн, хуулийн этгээдээс хүүтэй зээл авдаг зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 10 дугаар сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Зам, тээврийн сайд /Б.Дэлгэрсайхан/, тус яамны Төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /М.Баярмагнай/, Санхүү хөрөнгө оруулалтын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Г.Сумъяа/ нарт даалгав.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:



С.МАГНАЙСҮРЭН